

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР



БАЙГУУЛЛАГЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

## АГУУЛГА

|   |       |
|---|-------|
| НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН .....  | 2-9   |
| Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн<br>2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг,<br>нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, түүний<br>хэрэгжилт |       |
| ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ,<br>ҮР ДҮН .....   | 10-12 |
| ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН .....  | 13-42 |
| Дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд хийсэн ажлын хүрээнд:   |       |
| 3.1 Захиргааны дотоод ажлын чиглэлээр   |       |
| 3.2 НЗЗ-ны байруудын инженерийн байгууламжийн<br>ашиглалт, ус дулаан цахилгааны хэвийн,<br>найдвартай ажиллагааг ханган ажиллах чиглэлээр   |       |
| 3.3 Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, эрүүл<br>ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээ, хурлын заалны ашиглалт,<br>үйлчилгээний чиглэлээр  |       |
| ДӨРӨВ. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ<br>ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН<br>БИЕЛЭЛТ .....  | 43-47 |
| ТАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ .....   | 48-49 |
| ЗУРГАА БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ .....  | 50-55 |
| ДОЛОО. ДҮГНЭЛТ .....  | 56    |

## НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оныг “Нэг хот-нэг стандарт” зорилтот жил болгон зарласны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан 2020 оныг “Үйлчилгээний стандартын”-ын жил болгон зарлаж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудад чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг үзүүлж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын ажиллах тав тухтай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь 2020 онд удирдах төрийн захиргааны албан хаагч 1, төрийн үйлчилгээний нийт 277 ажилтан, албан хаагчийн орон тоотойгоор нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, түүний төрийн албан хаагчдад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1041 дугаар захирамжийн дагуу Захиргаа, санхүүгийн хэлтэс, Үйлчилгээний алба, Байр ашиглалтын алба гэсэн бүтэцтэйгээр Нийслэлийн Засаг захиргааны 1, 2, 3, 4, 5 дугаар байрууд болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 141 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны “Ухаалаг Улаанбаатар хөтөлбөр батлах тухай”, 2015 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах тухай” 185 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн Дүнжингарав, Мишээл, Драгон, Оргил салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн цэвэрлэгээ, үйлчилгээ, байр ашиглалтыг хариуцан ажилласан.

Тус байгууллага нь Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагуудын хэмжээнд төрийн үйлчилгээг хэвийн жигд тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө, санхүүг төлөвлөн зарцуулах, хөрөнгө материалын ашиглалт, хадгалалтад хяналт тавих, ажил үйлчилгээний төсвийг хянах, хянагдаж батлагдсан төсөв хөрөнгийн төлбөр тооцооны гүйлгээг цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх санхүүгийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Мөн Хангарди ордны зоогийн газар, НЗДТГазар, Улаанбаатар чуулгын байруудад байрлах цайны газрууд нь төрийн албан хаагчдад зориулсан өдөр тутмын зоог болон төрийн томоохон хүлээн авалт, хээрийн зоогийн үйлчилгээг технологийн дагуу үзүүлж байна.

### **Зорилтот жилийн хүрээнд:**

“Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь “Үйлчилгээний стандарт”-ын жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 9 заалттайгаар боловсруулан 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр баталсан. Тус төлөвлөгөөний холбогдох заалтуудыг нэгжүүдийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

1. “Чанарын удирдлагын менежментийн тогтолцоо /ISO9001/” олон улсын стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд “Төслийн удирдлагын хөгжлийн хүрээлэн”-гийн захирал Ц.Өнөржаргалтай удирдлагын түвшинд уулзаж, чанарын багийнханд сургалт зохион байгуулан ажилласан. Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах чанарын багийг томилох, бэлтгэл ажлыг хангах, албан хаагчдаас тус стандартыг нэвтрүүлэхтэй холбоотой судалгааны ажлыг тус тус хийлээ.

2. Тайлант хугацаанд НЗЗ-ны 5-р байр буюу Улаанбаатар чуулгын 1-р давхрын үзвэрийн танхимын орц, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан, стандартын шаардлага хангасан орц, гарцтай болгон тохижуулсан. Мөн НЗЗ-ны 5-р байр буюу Улаанбаатар чуулгын 1-р давхрын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан тохижуулсан ариун цэврийн өрөөг “Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо”-гоор дахин үнэлгээ хийлгэн, стандарт шаардлагад нийцүүлэн сайжруулж тохижуулсан.

Нийслэлийн засаг захиргааны байруудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарц, ариун цэврийн өрөөг стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хийж байна.



Зураг 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орц, гарц



Зураг 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө

3. Байгууллагад мөрдөгдөж байгаа цэвэрлэгээ үйлчилгээний стандартыг “Нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” болгон шинэчилж, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газраас стандартын код авсан ба тус газраас өгсөн зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулж, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулахад бэлэн болгон хүлээлгэн өгсөн.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага” стандартыг шинэчлэн боловсруулж, Хотын стандарт, орчны аюулгүй

байдлын хяналт зохицуулалтын газраар хянуулан 2 байгууллагын зөвшилцсөнөөр газрын даргын тушаалаар баталгаажуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

4. Тайлант хугацаанд НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын гаднах орчны 50 метр хүртэлх талбайн эд зүйлсийн эвдрэл, цахилгааны утасны аюулгүй байдлын үзлэгийг 12 удаа зохион байгуулж, ажилтан, албан хаагчид, иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.

- Халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх ажлыг 17 удаа зохион байгуулж нийт 32,600 метр квадрат газрын цас, мөсийг цэвэрлэсэн.

- Мөн 2700 орчим метр квадрат талбайн хогийг цэвэрлэх, ариутгалын бодисоор халваргүйжүүлэх ажлыг 14 хоног тутам хийж, цэвэр, аюулгүй орчин бүрдүүлж ажиллаа.

- НЗЗ-ны байруудад үйл ажиллагаа явуулж буй 4 байгууллагын хаягжилтыг стандартын дагуу шинэчлэн солиулсан.

5. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан хаврын тохижилтын ажлыг зохион байгуулж, НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу дэд төвийн гадна талбайд мод тарьж, зүлэгжүүлж, цэцгийн үр суулгаж ажилласан ба арчилгааг тогтмол хийсэн ба орчны хайс, цэцгийн мандлыг будах зэрэг гадна орчны тохижилтыг ажилтан, албан хаагчид хийж, гүйцэтгэлээ.

“Цэцэгжүүлэлт хийх, цэцэг, ногоон байгууламжийг арчлах” сэдэвт сургалтыг “Ногоонбаатар-2020” төслийн удирдагч Б.Шижирбаттай хамтран ажилтан, албан хаагчдад зохион байгуулсан.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн байруудын гадна орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний замыг цэвэрлэх ажлыг өдөр тутамд хийж, хогийн цэг, тамхи татах цэгүүдэд долоо хоног тутамд их цэвэрлэгээг хийж “Олон нийтийн газар нус, цэр, шүлсээ хаяхгүй, ил задгай хог хаягдлаар орчноо бохирдуулахгүй байх” санамжийг байршуулан ариутгал, халдваргүйжүүлэлтийг 8150 м2 талбайд 44 удаа хийж цэвэр орчин бүрдүүлэн ажиллаж байна.

6. НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд ангилан ялгах хогийн савыг байршуулах ажлыг зохион байгуулсан ба хог ангилан ялгах ажлыг хэвшүүлээд байна. Нийслэлийн засаг захиргааны 1, 2, 4, 5 дугаар байрууд, Баянхошуу дэд төвийн гадна талбайд нэгдсэн хог ангилан ялгах эко хогийн савыг шинээр хийж байршуулсан.



Зураг 3. Ангилан ялгах хогийн сав

"Хог, хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах" сэдэвт сургалтыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран НЗЗ-ны байрууд, НҮНТөвийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын болон аж ахуй нэгж, байгууллагын 94 ажилтан, албан хаагч, ННҮГазраас нийт 130 ажилтан, албан хаагч хамрагдлаа. Мөн "Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах" чиглэлээр байгууллагын "Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар" пэйж хуудас, [www.Khangardi.mn](http://www.Khangardi.mn) цахим хуудсуудаар дамжуулан иргэд олон нийтэд сурталчлах, нөлөөллийн ажлуудыг хийж ажилласан байна.

7. Байгууллагад мөрдөгдөх хоол, зоогийн үйлчилгээний стандартын эмхтгэлийг боловсронгуй болгох ажлын хүрээнд хүндэтгэл, хүлээн авалтанд ашиглагдах, зурган цэс боловсруулахад шаардлагатай хоолны зураг авалтын ажлыг эхлүүлсэн ба зоогийн газраас гарч буй хог хаягдлыг бүрэн ангилан ялгаж, Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ ХХК-иас компаниас тусгай тээвэрлэлтийн машины ачилтад нийлүүлж байна.

8. Тайлант хугацаанд нийт 19 удаагийн стандарт, норм, дүрмийн сургалт, семинарт давхардсан тоогоор 369 ажилтан, албан хаагчийг хамруулсан байна.

"Нэг хот-Нэг стандарт" зорилтот жилийн хүрээнд зохион байгуулагдсан болзолт уралдааны 2 дугаар улирлын шалгаруулалтад "Шилдэг байгууллага"-аар шалгарлаа.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд, ажилтан, албан хаагчдад нийтлэг үйлчилгээний нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### 5. ЗАСАГЛАЛ

#### 5.1 Оновчтой бүтэц, уялдаатай үйлчилгээ, хариуцлагатай албан хаагч

**5.1.2 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.2 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-3 дахь хэсэг** *“Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын стратеги төлөвлөгөө, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн үр дүнг тооцох, албан хаагчдын сургалтын цахим систем /ERP-ийн дэд систем/ дэх мэдээллийн санг ашиглаж хүний нөөцийн чадавхийг хөгжүүлнэ.”*

Тайлант хугацаанд байгууллагын аливаа мэдээ, мэдээллийг тус системд тухай бүр нь байршуулан ажиллахаас гадна хүний нөөцтэй холбоотой мэдээллийг дараах байдлаар хөтлөн ажиллалаа.

- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоол дагуу ажилтан албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх ажлын хүрээнд шинээр томилогдсон 73 ажилтан, албан хаагчдыг дотоод удирдлагын системд хувийн хэрэг үүсгэн, цаг бүртгэлд холбон, хандах эрх нээсэн,

- Өндөр насны тэтгэвэрт гарсан 19, ажлаас чөлөөлөгдсөн 32 ажилтан, албан хаагчдыг мэдээллийг мэдээллийн системээс идэвхгүй болгосон,

- Дэвшин болон шилжин ажилласан 37, жирэмсний болон хүүхэд асрах чөлөө 26, чөлөө болон тэтгэмж олгосон 36, хөдөлмөрийн хөлстэй холбоотой 36 ажилтан, албан хаагчийн мэдээллийг хүний нөөцийн удирдлагын системд холбогдох тушаалын дагуу албан тушаалыг өөрчилсөн,

- Хүүхэд асрах чөлөөтэй байсан 9 ажилтан, албан хаагчдыг ажилдаа эргэн орсныг төрийн албан хаагч дэд системд холбогдох тушаалын дагуу албан тушаалыг оруулсан,

- Ажилтан, албан хаагчдын ажлын цаг бүртгэлийг хурууны хээ мэдрэгч төхөөрөмжөөр бүртгэн ажилласан бөгөөд цаг ашиглалтын тайланг тус системээр нэгтгэн гаргаж ажиллалаа.

Газрын даргын шуурхай зөвлөгөөн болон биечилж өгсөн нийт 28 үүрэг даалгаврыг тус системийн “Үүрэг даалгавар”-ын модулиар шилжүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллалаа.

Мөн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгааг тус системийн “Судалгаа” цэсээр буюу цахим хэлбэрээр авсан ба судалгаанд нутгийн захиргааны байгууллагуудын 517 албан хаагч санал, сэтгэгдэлээ ирүүлсэн.

**5.1.6 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.6 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-7 дахь хэсэг** *“Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.”*

Байгууллагын ажилтан, албан хаагчдын ёс зүйг сахиулах, харилцаа хандлагыг дээшлүүлэх, стандарт, норм, дүрэм, хэм хэмжээг сурталчлан таниулах, дагаж мөрдүүлэх чиглэлээр сургалтуудыг цаг үеийн нөхцөл байдалд тохируулан үе шаттайгаар зохион байгуулсан ба тайлант хугацаанд 5 удаагийн сургалт, зөвлөгөөнд 87 ажилтан, албан хаагчийг хамрууллаа.

Ёс зүйн зөвлөл нь тайлант хугацаанд 7 ажилтан, албан хаагчид холбогдох гомдол мэдээллийн дагуу 8 удаа хуралдаж, холбогдох шийдвэрийг гаргаж ажиллалаа. Үүнээс:

- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.2-т заасан арга хэмжээг 2 ажилтанд,
- Дээрх журмын 5.4-т заасны дагуу 5 ажилтанд сахилгын зөрчил ногдуулах саналыг газрын даргад хүргүүлсэн.

**Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-14 дэх хэсэг “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулна.”**

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах ажлын хүрээнд НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн байруудад ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж, байруудад нэвтэрч буй иргэд, албан хаагчдын халууныг хэмжин, гарыг ариутган ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын ажиллах ая тухай орчин, нөхцөлийг бий болгох зорилгоор НЗЗ-ны байруудын тохижилт, өвөлжилтийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, засварын ажлуудыг тухай бүр нь хийлээ.

Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын баталсан “Амны хаалтаа зүүцгээе” аяны хүрээнд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан “Амны хаалт-Таны баталгаа” чэлленж хөдөлгөөнийг өрнүүлэн олон нийтийн сүлжээгээр ажилтан, албан хаагч болон иргэд олон нийтийг уриалан ажиллалаа.

Мөн Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын нийт ажилтан, албан хаагчдыг өөрийн оршин суух дүүрэг, хороонд харьяаллын дагуу коронавирүсийн PCR шинжилгээнд хамрагдах үүрэг өгсөн ба 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 277 ажилтан, албан хаагч шинжилгээнд бүрэн хамрагдаад байна.

Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 381 жилийн ойн баярын тохиолдуулан байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд спортын наадмыг 2020 оны 10 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс, ширээний теннис гэсэн 4 төрлөөр амжилттай зохион байгууллаа. Спортын наадамд байгууллагаас 9 баг 80 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцож, тэргүүн байрыг Г.Батзаяа ахлагчтай “Galaxy” баг шалгарч “ШИЛЖИН ЯВАХ ЦОМ”-ын эзэн болсон бөгөөд 2 дугаар байрт Б.Хэнмэдэх ахлагчтай “Пирари” баг, 3 дугаар байрт Б.Галмандах ахлагчтай “Нэрээ бодоорой” баг тус тус шалгарсан.

НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн инженерийн шугам сүлжээ, цэвэр бохир усны хэвийн, жигд ажиллагаанд слесариуд 3 цаг тутам хяналт тавьж, тэмдэглэл хөтлөн ажиллаж байгаа ба гэмтэл доголдлыг шуурхай барагдуулан ажиллаж байна.

Тайлант хугацаанд НЗЗ-ны 3-р байрны халаалтын ерөнхий шугам нь Чингэлтэй дүүрэг болон Берлин зоогийн газрын халаалтын буцах шугам хоолойн хэсэгт зэвэрч цоорсон гэмтлийг олж тогтоон шуурхай засварлан хэвийн, найдвартай ажиллагааг хангасан. 5-р байрны гадна шугамын 150 м зайд 125Ф хүйтэн усны шугамын хөрс хуулж, сувгийг шинээр сольж, стандартын дагуу дулаалах, худагт 125Ф таслах хаалт байрлуулах, барилга доторх 150м ерөнхий шугамын 125Ф-176Ф диаметртэй хэсэгт хөдлөх болон үл хөдлөх тулгуурын бэхэлгээг бүхэлд нь шалгаж, эвдэрч гэмтсэн хэсгийг шинэчлэн, таслах хаалт, тоолуур, даралт мэдрэгч, даралтын заалт зэргийг стандартын дагуу байршуулах ажлыг “Эрдэнэ талст инженеринг” ХХК-р гүйцэтгүүлэн хүлээн авсан ба сантехникийн шугам хоолойн хэвийн найдвартай, жигд ажиллагааг ханган ажиллалаа.

Байруудын цахилгааны щитны өрөө, цахилгааны утасны аюулгүй байдал, үзлэгийг улирал бүр хийж, цахилгааны шугам сүлжээний хэвийн найдвартай жигд ажиллагааг ханган, гэмтэл доголдлыг шуурхай барагдуулан ажиллалаа.

Тайлант хугацаанд НЗЗ-ны 3-р байрны цахилгааны засварын ажлыг “Дүүрэн гол” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу ерөнхий щитийг бүрэн тоноглож автоматжуулж, группийн щит,



давхруудын хуваарилах самбаруудыг бүрэн шинэчилж, засварлуулан гүйцэтгэлийг хууль журмын дагуу хүлээн авч, цахилгаан, эрчим хүчний найдвартай жигд, хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.

Мөн байруудын засвар, мужааны холбогдолтой ажил үйлчилгээг шуурхай, чанартай хийж гүйцэтгэсэн ба 2020 онд 1007 дуудлагыг хүлээн авч, шуурхай барагдуулж ажиллалаа.

НЗЗ-ны 2, 4-р байрны ачааны болон хүн зөөврийн 6 цахилгаан шатны ээлжит үзлэгийг "Сима Тек" ХХК-иар сар бүр хийлгэж, шаардлагатай тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийлгэн, хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа.

Тайлант хугацаанд НЗЗ-ны 2-р байрны 2, 3-р цахилгаан шатны ган татлага буюу гинж, бүхээгний гулсагч, батарей, мэдрэгч зэргийг шинээр солиулсан.

2020 онд инженерийн байгууламж, засвар үйлчилгээтэй холбоотой нийт 2694 дуудлагыг хүлээн авч шуурхай барагдуулан ажилласан ба энэ нь 2019 онтой харьцуулахад 43%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2020 онд үзүүлсэн үйлчилгээний чанар сайжирсныг харуулсан эерэг үзүүлэлт гарч байна.

### **5.3 ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ИЛ ТОД БАЙДАЛ**

**5.3.7 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.7 дэх заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-42 дахь хэсэг "Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулна"**

Тайлант хугацаанд нийт 184 өргөдөл ирсэнийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид биечлэн болон бичгээр танилцуулсан байна. Мөн хугацаанд өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа тогтмол шинжтэй байна.

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 17 цаг 43 минут байгаа нь 2018 оны үзүүлэлтээс буурсан боловч 2019 оны үзүүлэлтээс өссөн дүнгээр харагдаж байгаа нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж буй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т заасан хугацааг баримтлах болсонтой холбоотой юм.

**5.3.9 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3.9 дэх заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-43 дахь хэсэг "Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх замаар байгууллагуудын дотоод хяналтын тогтолцоог сайжруулна."**

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө, календарьчилсан хуваарийг 02 дугаар сарын 05-ны өдөр баталж, хэрэгжилтийг дараах байдлаар ханган ажиллалаа.

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ,
- Зоогийн газар, цайны газруудын үйл ажиллагаа,
- НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу дэд төвийн цэвэрлэгээ үйлчилгээ болон ариутгал халдваргүйжүүлэлт,
- Байр ашиглалтын албаны үйл ажиллагаа,
- Байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

нийт 16 удаагийн дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний ажлыг зохион байгуулсан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын дүнг холбогдох албан хаагчдад танилцуулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор нийслэлийн засаг захиргааны байрууд, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авах ажлыг цахим хэлбэрээр зохион байгууллаа. Тус судалгаанд НЗЗ-ны байрууд болон НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа 517 ажилтан, албан хаагч хамрагдлаа. Судалгааны дүнгээс харахад манай байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд судалгаанд оролцогчдын 65% буюу дийлэнх хэсэг нь сайн үнэлгээ өгсөн ба төрийн албан хаагчдаас гаргасан санал, хүсэлтийг судлан үзэж, шийдвэрлэн ажиллах үүргийг холбогдох албан хаагчид өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Байгууллагын 278 ажилтан, албан хаагчийн ур чадварыг газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, байгууллагын “Ажилтан, албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журам”-ын дагуу улирал бүр дүгнэн ажилтан, албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг сар бүр тооцон олгож ажилласан.

Мөн газрын даргын 2020 оны А/36 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний баг ажилтан, албан хаагчдын улирлын ажлын гүйцэтгэлийн үр дүнг “Нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, тайлагнах, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу улирал бүр дүгнэн зохих урамшууллыг олгож ажиллалаа.

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас үнэлгээтэй холбоотой гомдол, санал ирүүлээгүй байна.

#### **5.4 ТОГТВОРТОЙ БОДЛОГО – ХАМТЫН АЖИЛЛАГАА**

**5.4.7 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.7 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-64 дэх хэсэг, “Улаанбаатар хотын гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө 2019-2020”-г хэрэгжүүлнэ.**

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчилсэн загвараар боловсруулан ЧД-ийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран баталж, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын гамшгаас хамгаалах орон тооны бус штаб, зарлан мэдээлэх схем, шуурхай бүлэг байгуулан гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Мөн коронавирусын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг баталлаа.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Хууль тогтоомж, НИТХ-ын тогтоол, нийгэм эдийн засгийн зорилт, Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц үр дүнг тайлагнаж ажиллах

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу тайлант хугацаанд нийт 19 төрлийн захирамжлалын баримт бичгийн 37 зүйл заалтын хүрээнд тайлан мэдээг бэлтгэж, сар улирлаар 1-3 удаагийн давтамжтайгаар заасан хугацаанд [www.monitoring.ulaanbaatar.mn](http://www.monitoring.ulaanbaatar.mn) цахим сайтад байршуулахын зэрэгцээ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст цахим болон цаасан суурьтайгаар хүргүүлж ажиллалаа. Тодруулбал:

Хүснэгт 1

| Д/д | Захирамжлалын баримт бичгийн төрөл                 | Захирамжлалын баримт бичгийн тухай   | Хамаарах зүйл заалт | Тайлан өгсөн давтамж |
|-----|--|--|---------------------|----------------------|
| 1.  | Монгол улсын хууль                                 | 1. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль | 9                   | 1                    |
| 2   | Засгийн газрын тогтоол                             | 2. Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай /№2018-258/  | 10                  | 1                    |
|     |  | 3. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай /№2020-183/          | 5                   | 1                    |
| 3   | Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл | 4. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 3 дугаар хуралдааны тэмдэглэл /№2020-03/03/   | 1                   | 2                    |
|     |  | 5. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл /№2020-06/04  | 1                   | 2                    |
|     |  | 6. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 7 дугаар хуралдааны тэмдэглэл /№2020-07/01/   | 2                   | 4                    |
|     |  | 7. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 21 дүгээр хуралдааны тэмдэглэл /№2020-11/06/  | 7                   | 7                    |
| 4   | Нийслэлийн Засаг даргын захирамж                   | 8. “2020 оныг Нэг хот – Нэг стандарт зорилтот жил болгон зарлах тухай” /№2020-А/01/  | 1                   | 3                    |
|     |  | 9. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /№2020-А/108/   | 1                   | 2                    |
|     |  | 10. Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай /№2020-А/168/   | 1                   | 3                    |
|     |  | 11. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай /№2020-А/346/                                       | 1                   | 2                    |
|     |  | 12. Коронавируст /КОВИД-19/ халдвараас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай /№2020-А/436/         | 2                   | 4                    |
|     |  | 13. Өнжмөл шар өвсний түймэр гарахаас урьдчилан сэргийлэх тухай /№2020-А/487/  | 1                   | 3                    |
|     |  | 14. Хугацаа сунгах тухай /№2020-А/483/   | 1                   | 2                    |
|     |  | 15. Захирамжид өөрчлөлт оруулах тухай /№2020-А/590/  | 2                   | 4                    |

|      |   |  |    |    |
|------|---|--|----|----|
|      |   | 16. Захирамжид өөрчлөлт оруулах тухай /№2020-А/752/  | 1  | 1  |
|      |   | 17. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /№2020-А/801/                    | 1  | 3  |
|      |   | 18. Коронавируст /Ковид-19/ цар тахлын үед эдийн засгийг дэмжих зарим арга хэмжээний тухай /№-2020-А/930/              | 1  | 1  |
|      |   | 19. Ажил эрчимжүүлэх тухай /№2020-950/   | 1  | 2  |
|      |   | 20. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж, хяналт тавих тухай /№2020-А/1036/  | 3  | 6  |
|      |   | 21. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /№2020-А/1242/ | 3  | 3  |
| 5    | Улсын Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгавар      | 22. Улсын Онцгой комиссын 36 дугаар хурлын тэмдэглэл   | 2  | 1  |
|      |   | 23. Улсын Онцгой комиссын 37 дугаар хурлын тэмдэглэл   | 1  | 1  |
|      | Нийслэлийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгавар | 24. Нийслэлийн Онцгой комиссын 8 дугаар хурлын тэмдэглэл   | 3  | 9  |
|      |   | 25. Нийслэлийн Онцгой комиссын 14 дүгээр хурлын тэмдэглэл  | 3  | 6  |
| Нийт |   | 25   | 69 | 74 |

2.3 Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын албан даалгаврын хэрэгжилтийн тайлан мэдээг сар бүр гаргаж, тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлж ажиллах төлөвлөгөөний хүрээнд:

“Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын дагуу тайлант хугацаанд 17 төрлийн захирамжлалын баримт бичгийн 20 заалтын биелэлтийн мэдээг 1-11 удаагийн давтамжтайгаар нэгтгэн гаргаж, edoc программаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Эдгээр захирамжлалын баримт бичгүүдийг тодруулбал:

|     |                                    |  |                     | Хүснэгт 2            |  |
|-----|------------------------------------|--|---------------------|----------------------|--|
| Д/д | Захирамжлалын баримт бичгийн төрөл | Захирамжлалын баримт бичгийн тухай   | Хамаарах зүйл заалт | Тайлан өгсөн давтамж |  |
| 1   | Нийслэлийн Засаг даргын захирамж   | 1. “2020 оныг Нэг хот – Нэг стандарт зорилтот жил болгон зарлах тухай” /№2020-А/01/                    | 1                   | 11                   |  |
|     |                                    | 2. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /№2020-А/108/ | 1                   | 10                   |  |
|     |                                    | 3. “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” /№2019-А/1016/                                  | 1                   | 3                    |  |
|     |                                    | 4. Уриалга гаргах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай /№2020-А/168/       | 1                   | 7                    |  |
|     |                                    | 5. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /№2020-А/191/                 | 2                   | 8                    |  |
|     |                                    | 6. 12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг хорогдуулах тухай /№2020-А/268/                   | 1                   | 4                    |  |

|      |  |   |    |    |
|------|--|---|----|----|
|      |  | 7. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай /№2020-А/346/                               | 1  | 2  |
|      |  | 8. Коронавируст /КОВИД-19/ халдвараас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлыг эрчимжүүлэх тухай /№2020-А/436/ | 1  | 2  |
|      |  | 9. Хугацаа сунгах тухай /№2020-А/483/   | 1  | 2  |
|      |  | 10. Өнжмөл шар өвсний түймэр гарахаас сэргийлэх тухай /№2020-А/487/   | 1  | 3  |
|      |  | 11. Захирамжид өөрчлөлт оруулах тухай /№2020-А/752/   | 1  | 1  |
|      |  | 12. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж, хяналт тавих тухай /№2020-А/1036/   | 2  | 1  |
|      |  | 13. Захирамжийн хугацааг сунгах тухай /№2020-А/1129/  | 1  | 3  |
|      |  | 14. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшүүлэх тухай /№2020-А/1067/   | 1  | 3  |
|      |  | 15. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /№2020-А/1242/                    | 3  | 2  |
| 2    | Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл | 16. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 01 дүгээр хуралдааны тэмдэглэл   | 1  | 6  |
|      |  | 17. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 06 дугаар хуралдааны тэмдэглэл   | 1  | 1  |
| Нийт |  |   | 17 | 69 |




График 1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээг өмнөх онтой харьцуулсан байдал

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

### Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд:

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/666 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрэм шинэчлэн батлах тухай” дүрэмд тусгасан дараах 7 үндсэн чиг үүргийн дагуу НИТХ, НЗДТГ, Захирагчийн ажлын алба, хэрэгжүүлэгч агентлагууд болон Нийслэлийн Засаг захиргааны байруудад байрлан ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

### 3.1 Захиргаа, дотоод ажлын чиглэлээр

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх, мөн 2020 оныг “Нэг хот нэг стандарт”-ын жил болгон зарласантай холбогдуулан Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь 2020 оныг “Үйлчилгээний стандарт”-ын жил болгон зарлаж, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж Нийслэлийн засаг захиргааны байруудын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд үйлчилгээ, техникийн ажилтнуудын оролцоог нэмэгдүүлж, шинэ санал санаачилгыг дэмжин, идэвхжүүлэн урамшуулж ажиллалаа.

#### 3.1.1 Хүний нөөцийн чиглэлээр:

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр ажлын байрны сул орон тоог байгууллагын цахим хуудас [www.khangardi.mn](http://www.khangardi.mn) болон зарын нэгдсэн цахим хуудас [www.unegui.mn](http://www.unegui.mn), [www.biznetwork.mn](http://www.biznetwork.mn), байгууллагын мэдээллийн ил тод байдлын самбарт тухай бүр байршуулж нийтэд мэдээлэхийн зэрэгцээ ажлын байрны зарыг Хөдөлмөр эрхлэлтийн газар болон дүүргүүдийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд ажлын байрны 73 сул орон тоонд 115 ажил горилогч материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн ба анкет, хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийж, 73 иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

Мөн байгууллагын 278 ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг ханган ажиллалаа. Мөн ажлын байрны сул орон тоонд зохих шаардлагыг хангасан 13 ажилтан, албан хаагчийг албан тушаал дэвшүүлэн томилсон байна.



Зураг 4. Нээлттэй ажлын байрны зар

Тайлант хугацаанд цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан ажилтан, албан хаагчдын судалгааг тухай бүр гарган холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажилласан. Тухайлбал:

- Төрийн албанд ажилласан жилийн судалгаа,
- Шагналын судалгаа,
- Дэвшин ажиллаж байгаа ажилтан албан хаагчдын судалгаа,
- Шинээр ажилд томилогдсон ажилтан, албан хаагчдын судалгаа,

- Орон сууцны судалгаа,
- Ажилтан, албан хаагчдын хаягийн судалгааг
- Одонтой ээжийн судалгаа,
- Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн судалгаа,
- Ахмадын судалгаа,
- 50-иас дээш насны ажилтан, албан хаагчдын судалгаа,
- Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, албан хаагчдын судалгаа,
- 0-3 насны, 3-5 насны хүүхэдтэй эхчүүдийн судалгаа,
- 0-12 насны хүүхэдтэй эхчүүдийн судалгаа,
- Ажилтан, албан хаагчдын 0-15 насны хүүхдийн судалгаа
- Жирэмсний амралт, хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтан албан хаагчдын судалгаа,
- Хугацаат цэргийн алба хаасан ажилтан, албан хаагчдын судалгааг

тус тус гаргасан.

Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тогтвор суурьшлыг хангах үүднээс Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын 2020 онд ажилтан, албан хаагчдад зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг баталсан ба тус төлөвлөгөөнд 23 арга хэмжээ төлөвлөснөөс 19 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, давхардсан тоогоор 399 ажилтан, албан хаагчийг сургалтад хамруулсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 82.6%-ийн биелэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал үзүүлэлт 7.4%-иар буурсан нь цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой гэж үзэж болно.



График 2. Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг өмнөх онтой харьцуулсан байдал

Мөн дээд газраас болон бусад байгууллагаас зохион байгуулагдсан 11 удаагийн сургалтад давхардсан тоогоор 66 албан хаагчийг ажил үүргийн чиглэлийн дагуу хамруулсан.



Зураг 5. Зохион байгуулагдсан сургалтуудын үеэр

Байгууллагын хэмжээнд 2020 онд ажлын бус цагаар өөрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэн нягтлан бодох бүртгэл мэргэжлээр 2 албан хаагч суралцаж төгссөн бол газар зохион байгуулалт, хэл шинжлэл, эрх зүй, ХАБЭА мэргэжлээр 5 албан хаагч тус тус суралцаж байна.

### 3.1.2 Тушаал шийдвэрийн талаар:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан даргын тушаал 69, Байгууллагын хүний нөөцийн чиглэлээр гаргасан даргын тушаал 350 тус тус батлагдан гарч хэрэгжилтийг ханган ажилласан болно.



График 3. Сүүлийн 3 жилд гарсан тушаалуудын тоог харьцуулсан байдал

### 3.1.3 Өргөдөл гомдлын талаар:

Тайлант хугацаанд байгууллагын ажилтан, албан хаагчдаас хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар 197 өргөдөл ирснийг бүрэн шийдвэрлэж хариуг өргөдөл гаргагчид биечлэн болон бичгээр танилцуулсан ба иргэдээс өргөдөл, гомдол ирүүлээгүй байна. Өргөдөл гомдлын бүртгэл, явц болон шийдвэрлэлттэй холбоотой ямар нэгэн зөрчил гараагүй, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа тогтмол шинжтэй байна.

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 17 цаг 43 минут байгаа нь 2018 оны үзүүлэлтээс буурсан боловч 2019 оны үзүүлэлтээс өссөн дүнгээр харагдаж байгаа нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцалж буй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т заасан хугацааг баримтлах болсонтой холбоотой юм.



График 4. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг өмнөх онтой харьцуулсан байдал

Тайлант хугацаанд ирсэн өргөдлийг ангилан авч үзвэл:

- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой – 54
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой – 52
- Цалинтай болон цалингүй чөлөө хүсэхтэй холбоотой – 51



- Жирэмсний амралт хүсэхтэй холбоотой – 24
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай – 26
- Бусад – 3



График 5. Ирсэн өргөдлийг төрлөөр ангилан харуулав

Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар:

Нийслэлийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/252 дугаар захирамж “Нийслэлийн байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөх албан хэрэг хөтлөлтийн ажлын нийтлэг журам”, газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/16 тушаалаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтын журам”-ыг байгууллагын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газар 2019 онд 37, 38 дугаар тогтоолоор “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” батлан гаргасан. Шинэчилсэн загвар гарсантай холбогдуулан Удирдлагын академийн багш, доктор М.Амартүвшинг урин 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр “Гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээ, тайлагналтыг боловсруулах аргачлал”-ын сургалт зохион байгуулсан. Сургалтад захиргаа, санхүүгийн хэлтсийн 45 албан хаагч хамрагдлаа.



Зураг 6. Сургалтын үеэр

Тайлант хугацаанд ирсэн албан бичиг 357 үүнээс хариутай бичиг 95, хариугүй 262 бичиг хүлээн авч холбогдох хэлтэс, албадад шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан.

Ирсэн албан бичгийг хэлтэс, албадаар нь ангилан хүснэгтээр харуулбал

## Хүснэгт 3

| №  | Төрөл                      | Ирсэн бичгийн тоо | Ирүүлсэн хэлбэр  |                                       |                                   |                      | Шийдвэрлэлт          |                    |                                    |                        | Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь |
|----|----------------------------|-------------------|--|---------------------------------------|-----------------------------------|----------------------|----------------------|--------------------|------------------------------------|------------------------|--|
|    |                            |                   | Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр бүртгэгдсэн бичгийн тоо | Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо | Системээр бүртгэгдсэн бичгийн тоо | Хариутай бичгийн тоо | Хариугүй бичгийн тоо | Хугацаандаа хаасан | Шийдвэрлэлтийн шатанд байгаа бичиг | Хугацаа хэтэрсэн бичиг |  |
| 1. | Удирдлага                  | 19                | 0  | 2                                     | 17                                | 2                    | 17                   | 19                 | 0                                  | 0                      | 100%                                   |
| 2. | Захиргаа санхүүгийн хэлтэс | 254               | 1  | 18                                    | 235                               | 86                   | 168                  | 251                | 0                                  | 1                      | 99.94%                                 |
| 3. | Байр ашиглалтын алба       | 72                | 0  | 11                                    | 61                                | 6                    | 66                   | 72                 | 0                                  | 0                      | 100%                                   |
| 4. | Үйлчилгээний алба          | 12                | 0  | 1                                     | 11                                | 1                    | 11                   | 12                 | 0                                  | 0                      | 100%                                   |
| 5. | <b>Нийт ирсэн бичиг</b>    | <b>357</b>        | <b>1</b>   | <b>32</b>                             | <b>324</b>                        | <b>95</b>            | <b>262</b>           | <b>258</b>         | <b>0</b>                           | <b>1</b>               | <b>99.96%</b>                          |

Тайлант хугацаанд 530 албан бичгийг дээд шатны байгууллага, нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, бусад гадны байгууллагад албан бичгийн стандарт, дүрэм, зааврын дагуу боловсруулж хүргүүлсэн ба Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс холбогдох газруудад явуулсан нийт 6563 албан бичгийг тус газрын 2 бичиг хүргэгч шуурхай хүргэж ажиллалаа.

Явсан албан бичгийг хэлтэс, албадаар нь ангилан хүснэгтээр харуулбал

## Хүснэгт 4

| №  | Төрөл                      | Явсан бичгийн тоо | Хариутай бичгийн тоо | Хариугүй бичгийн тоо | Хугацаа хэтрүүлж харуу ирүүлсэн | Шийдвэрлэх шатандаа | Хугацаа хэтэрсэн, харуу ирээгүй | Шийдвэрлэлтийн хувь |
|----|----------------------------|-------------------|----------------------|----------------------|---------------------------------|---------------------|---------------------------------|---------------------|
| 1. | Удирдлага                  | 4                 | 0                    | 4                    | 0                               | 0                   | 0                               | 100%                |
| 2. | Захиргаа санхүүгийн хэлтэс | 282               | 0                    | 282                  | 0                               | 0                   | 0                               | 100%                |
| 3. | Байр ашиглалтын алба       | 34                | 0                    | 34                   | 0                               | 0                   | 0                               | 100%                |
| 4. | Үйлчилгээний алба          | 5                 | 0                    | 5                    | 0                               | 0                   | 0                               | 100%                |
| 5. | <b>Нийт явсан бичиг</b>    | <b>325</b>        | <b>0</b>             | <b>325</b>           | <b>0</b>                        | <b>0</b>            | <b>0</b>                        | <b>100%</b>         |

## Хэвлэмэл хуудасны тайлан тооцоо

## Хүснэгт 5

| Он      | Хэвлэмэл хуудас | Нийт дүн | Устгасан | Ашигладсан хэвлэмэл хуудас | Үлдэгдэл |
|---------|-----------------|----------|----------|----------------------------|----------|
| 2020 он | A4 /тушаал/     | 1072     | 120      | 806                        | 138      |
|         | A5              | 1307     | 55       | 1080                       | 172      |
|         | A4              | 411      | 34       | 60                         | 317      |

2019 онд үүсч хөтлөгдсөн 321 хадгаламжийн нэгжийг 2020 оны 1 дүгээр улиралд акт үйлдэн хүлээн авснаас цаасан суурьтай 280, тусгай төрлийн 41 хадгаламжийн нэгжийг байнга, түр хадгалахаар хугацаагаар ангилсан.


2018 оны ХХНЖ-ын дагуу хүлээн авсан баримтын нэгдсэн тоо мэдээ

Хүснэгт 6

| Хэлтсийн нэр                | Байнга хадгалах | 70 жил хадгалах | Түр хадгалах | Тусгай төрөл | ХН-ийн тоо |
|-----------------------------|-----------------|-----------------|--------------|--------------|------------|
| Захиргаа, санхүүгийн хэлтэс | 58              | 24              | 173          | 41           | 296        |
| Байр ашиглалтын алба        | 3               | -               | 6            | -            | 9          |
| Үйлчилгээний алба           | 3               | -               | 13           | -            | 16         |
| <b>Дүн</b>                  | <b>64</b>       | <b>24</b>       | <b>192</b>   | <b>41</b>    | <b>321</b> |

Байгууллагын газрын даргын 2019 оны үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан А/01-69, боловсон хүчний чиглэлээр гаргасан Б/01-350 нийт 419 тушаалыг ArchiveEdoc цахим програмд тушаалын тэргүү, агуулга, он цагийн хязгаарыг шивэх, цахим хувийг хавсаргах гэх мэт ажлуудыг гүйцэтгэлээ. Архивын цахим програмд бүртгэгдсэн захирамжлалын баримтад нягтлан шалгалт хийсэн ажлын мэдээ, тайланг Нийслэлийн Архивын газарт илгээсэн.

Архивын өрөөнд улиралд нэг удаа буюу нийт 2 удаа хортон шавьж, мэрэгч амьтны устгалын хор цацуулж, ариутгал хийлгэсэн. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр ирүүлсэн зөвлөмжийн дагуу Хууль зүйн сайдын 2015 оны А/224 дүгээр тушаал “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүйн дүрэм”-ийг мөрдөж галын аюулгүйн дохиолол 2, хяналтын камер 4 ш суурилуулсан. НЗЗ-ны 5В байранд байрлах архивын хадгаламжийн сангын галын аюулгүйн ажиллагааг хангах ажлуудыг хийж архивын өрөө стандартын дагуу тохижуулсан.



Зураг 7. Архивын өрөөг тохижуулсан байдал

Тайлант хугацаанд иргэд, байгууллагын хүсэлтийн дагуу нийт 94 баримтад лавлагаа олгож, хуулбар үнэн тэмдэгт дарж, бүртгэл хөтөллөө.

3.1.5 Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, тогтвор суурьшлыг хангах, ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 2 чиглэлийн 18 арга хэмжээг төлөвлөн бүрэн хэрэгжүүлэн ажиллалаа. Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг үе шаттайгаар

шийдвэрлэх, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж нь хүний нөөцийн тогтвор суурьшлыг хангаж ажиллалаа. Тухайлбал:

Тайлант онд тус газар нь нийт ажилтан, албан хаагчдын амьдрах орчин нөхцөлийн судалгааг шинэчлэн нэгтгэж, улмаар НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчид тус газрын 80 гаруй хувь нь гэр хороололд амьдардаг болохыг уламжилж түрээслээд өмчлөх хэлбэрээр орон сууцжуулах төсөлд хамруулж дэмжлэг үзүүлэх хүсэлтийг гаргасан. Энэ хүрээнд НЗДаргаас 5 квотыг олгосноор ННУГазарт олон жил үр бүтээлтэй ажилласан байр хариуцсан менежер М.Мөнхцэцэг, слесарь О.Лхамсүрэн, үйлчлэгч Ц.Энхжаргал, Н.Саранцэцэг, тогооч Б.Оюун-Эрдэнэ нарын 5 хүнийг шалгаруулан тус төсөлд хамруулж, орон сууцанд хамрагдсан.



*Зураг 8. Ажилтан, албан хаагчдад байрны түлхүүр гардуулж байна*

Тайлант хугацаанд сар шинийн баяр, аравдугаар сарын 01-ний өдөр ННУГ-ын ахмадуудад хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулсан.

Өндөр насны тэтгэвэрт гарсан 19 ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламжид 282.680.245 төгрөг, ар гэрийн гачигдал гарсан 36 ажилтан, албан хаагчид өргөдлийг үндэслэн 11.856.727 төгрөг, гэр болон галлагаатай байшинд амьдардаг 32 ажилтанд түлээ, нүүрсний хөнгөлөлтөд 6.400.000 төгрөг, мөн ажилтан, албан хаагчдын хоол, тээврийн зардалд 272.243.500 төгрөгийг тус тус олгосон байна.



*Зураг 9. Түлшний хөнгөлөлтийн эрхийн бичиг гардуулах үеэр*

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”, тус газрын “Нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах, тайлагнах, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу 2020 онд нийт давхардсан тоогоор 327 ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийг үр дүнг улирал бүр үнэлж, 272.663.426 төгрөгийн урамшуулал олгон ажилласан.

Тайлант хугацаанд газрын даргын 2020 оны А/24, А/38, А/52 дугаар тушаалуудаар ажилтан, албан хаагчдын 2020 оны 1, 2, 3, 4 дүгээр улирлын ур чадварыг дүгнэх ажлын хэсгийг байгуулан ур чадварыг дүгнэж, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу нийт 329.843.861 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг сар бүр тооцон олгосон байна.

### 3.1.6 Эрүүл мэндийн чиглэлээр:

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5-14 дэх хэсэг “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулна” гэж заасны дагуу эрүүл амьдрах хандлага, зан үйлийг төлөвшүүлэх, ажлын байрны ажиллах нөхцөлийг сайжруулах, мөн коронавируст цар тахал дэгдсэнтэй холбогдуулан үе шаттайгаар ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын баталсан “Амны хаалтаа зүүцгээе” аяны хүрээнд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан “Амны хаалт-Таны баталгаа” чэлленж хөдөлгөөнийг өрнүүлэн НЗЗ-ны байруудад үйл ажиллагаа явуулдаг төрийн албан хаагч нарыг уриалан видео хэлбэрээр уриалга гарган олон нийтийн сүлжээнд байршуулан ажилласан. Тус тайланг 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдөр НЗДТГ-т хүргүүлсэн.



Зураг 10. Чэлленж хөдөлгөөний үеэр

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын нийт ажилтан, албан хаагчдыг өөрийн оршин суух дүүрэг, хороонд харьяаллын дагуу коронавирусийн PCR шинжилгээнд хамрагдах үүрэг өгсөн ба 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 277 ажилтан, албан хаагч шинжилгээнд хамрагдаад байна.

Тайлант хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэгийг нэмэгдүүлэх, дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу дэд төвийн ажилтнуудад ХАБЭА-н стандартыг мөрдөж ажлын байранд аюулгүй ажиллах онол, практикийн сургалтад 167, Монголын ариутгал халдваргүйжүүлэлтийн холбоо ТББ-ын тэргүүн Н.Баасанжавыг урин ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, төхөөрөмжийг хэрхэн ашиглаж хэрэглэх, ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр “Коронавирус халдварын сэргийлэлт, хяналт” сэдэвт сургалтад 35, мэргэшсэн инженер, багш Б.Бямбацэрэнг урин “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сургалтад 30 ажилтан, албан хаагчийг тус тус хамруулсан байна.



Зураг 11. Сургалтын явцаас

### 3.1.7 Биеийн тамир спортын талаар:

Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 381 жилийн ойн баярын тохиолдуулан биеийн тамир спортын хамтлаг нь нийтийн биеийн тамирыг сурталчлах, ажилтан, албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олны нөхөрлөлийг бэхжүүлэх зорилгоор байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд спортын наадмыг 2020 оны 10 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд гар бөмбөг, сагсан бөмбөг, дартс, ширээний теннис гэсэн 4 төрлөөр амжилттай зохион байгууллаа. Спортын наадамд байгууллагаас 9 баг 80 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин оролцож, тэргүүн байрыг Г.Батзаяа ахлагчтай “Galaxy” баг шалгарч “ШИЛЖИН ЯВАХ ЦОМ”-ын эзэн болсон бөгөөд 2 дугаар байрт Б.Хэнмэдэх ахлагчтай “Пирари” баг, 3 дугаар байрт Б.Галмандах ахлагчтай “Нэрээ бодоорой” баг тус тус шалгарсан.



Зураг 12. Байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд спортын наадам зохион байгуулав.

### 3.1.9 Санхүү, аж ахуйн чиглэлээр:

Төрийн үйлчилгээг хэвийн жигд тасралтгүй явуулахад шаардлагатай хөрөнгө санхүүг төлөвлөн зарцуулж, хөрөнгө материалын ашиглалт, хадгалалтад хяналт тавин, ажил үйлчилгээний төсвийг хянан, хянагдаж батлагдсан төсөв хөрөнгийн төлбөр тооцооны гүйлгээг цаг хугацаанд нь хийж, төсвийн гүйцэтгэлийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулж, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөн ажилласан.

Тайлант хугацаанд төсвийн гүйцэтгэлийн мэдээг 12 удаа гарган Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст, ННҮГ-ын ажилтан, албан хаагчдын сар бүрийн НДШ төлөлтийн тайланг дараа сарын 5-ны дотор ЧД-ийн НДХэлтэст 12 удаа явуулж баталгаажуулан ажиллаж байна. Мөн тайлан, мэдээг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст тухай бүр байршуулан ажиллалаа. Шилэн дансанд байршуулах 19 төрлийн мэдээг 59 удаа, тухай бүр байршуулах 8 төрлийн мэдээг цаг тухайд нь байршуулж ажилласан.

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч 12 агентлагийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч 7, агентлаг хариуцсан нярав 6 албан хаагчаар дамжуулан ямар нэгэн гомдол саналгүй иж бүрнээр үзүүлэн ажилласан.

Байгууллагын санхүүгийн тайлан мэдээг цаг тухайд нь гарган нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулан ажилласан. Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг хангаж, эд хариуцагчийн картын дотоод хөдөлгөөнийг Acolous програмд бүртгэлжүүлэн хөрөнгийн шилжилтийг эд хариуцагчид картлаж, хяналт тавьж ажилласан ба НӨАУГ-с Өмч эзэмшигчийн гэрээ байгуулан гэрээний хавсралтыг бүрдүүлж ажилласан. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хэрэгжилтийг улирал бүр буюу 2 удаа хуралдуулж холбогдох асуудлаар зөвлөлдөн шийдвэрлэж ажилласан. Мөн тайлант хугацаанд төсвийн гүйцэтгэлийн мэдээг 12 удаа гарган Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтэст, ННҮГ-ын ажилтан, албан хаагчдын сар бүрийн НДШ төлөлтийн тайланг дараа сарын 5-ны дотор ЧД-ийн НДХэлтэст 12 удаа явуулж баталгаажуулан ажиллаж байна. Тайлан, мэдээг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудаст тухай бүр байршуулан ажиллалаа. PAYROL-Цалингийн програмд нийт ажилтан албан хаагчдын цалингийн тооцоо, бүртгэл мэдээллийг сар бүр тушаал шийдвэрийн дагуу хөтөлж шинэ ажилчдын мэдээллийг бүртгэж програмд тооцооллыг хийж ажилласан. Цалингийн програм 9 дүгээр сард шинэчлэгдэн "Төрийн Албаны нэгдсэн систем"-д шилжиж, 2 цалингийн програмд тооцоолол хийж, шинэ системээр ажилчдын цалинг тавьж олгосон.

Бараа материалын тайланг сар бүр гарган, түлш, шатах тослох материалын тооцоог бодож НББ-ын үйл ажиллагааг тогтоосон журмын дагуу хөтлөн эд хөрөнгө бараа материалын хадгалалт, хамгаалалт, эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг ханган ажилласан. Тайлант хугацаанд агуулахын эд хөрөнгийг тус тус эмхэлж цэгцэлж, ариутгал халдваргүйтгэл, шавжгүйтгэл хийж ажилласан.

Эд хөрөнгийн тооллогыг газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хагас, бүтэн жилээр хийж, ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг акталж данснаас хасах ажлыг гүйцэтгэсэн.

Мөн газрын даргын 2019 оны А/85, 2020 оны А/20, А/28 дугаар тушаалаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулж, нээлттэй сонгон шалгаруулалтаар 1, харьцуулалтын аргаар 11, нийт 12 тендер шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, баримт бичгийн бүрдлийг хангаж ажилласан. Худалдан авах ажиллагааны талаарх тайлан мэдээг 12 удаа НХААГ-т хүргүүлэн ажиллалаа.

Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаатай холбоотой ямар нэгэн зөрчилгүй, гуравдагч этгээдээс гаргасан гомдолгүй ажиллаа.

### 3.1.7 Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Тогтоол шийдвэр, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж дотоод хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам", 2014 оны А/279 дүгээр захирамжаар баталсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам", бусад холбогдох дүрэм, журам, баримт бичгийг тус тус удирдлага болгон ажилласан.

### Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын талаар:

Байгууллагын үйл ажиллагаанд холбогдох захирамжлалын баримт бичгийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон [www.erp.ulaanbaatar.mn](http://www.erp.ulaanbaatar.mn) цахим хуудсанд тус тус байршуулан нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж байна. Мөн захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийн мэдээ тайланг Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн хавсралтаар баталсан хуваарийн дагуу сар бүр 4 төрөл, улирал бүр 7 төрлийн тайлан мэдээг эрх бүхий байгууллагад хүргүүлж ажилласан.

Тайлант хугацаанд Засгийн газрын 6 тогтоолын 16 заалт, Улсын Онцгой комисс болон нийслэлийн Онцгой комиссын 4 тэмдэглэлийн 9 заалт, Нийслэлийн Засаг даргын 20 захирамжийн 27 заалт, НЗД-ын зөвлөлийн хурлын 4 тэмдэглэлийн 13 заалтын хэрэгжилтэд тус тус хяналт тавин ажиллалаа. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт 99.7%-ийн гүйцэтгэлтэй байна.

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө, календарьчилсан хуваарийг 02 дугаар сарын 05-ны өдөр баталж, хэрэгжилтийг дараах байдлаар ханган ажиллалаа.

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ;
- Зоогийн газар, цайны газруудын үйл ажиллагаа;
- НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу дэд төвийн цэвэрлэгээ үйлчилгээ болон ариутгал халдваргүйжүүлэлт;
- Байр ашиглалтын албаны үйл ажиллагаа;
- Байгууллагын болон нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

нийт 16 удаагийн дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний ажлыг зохион байгуулсан байна. Тус төлөвлөгөөний хэрэгжилт 95%-ийн гүйцэтгэлтэй байна.

Сэтгэл ханамжийн судалгааны талаар

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор нийслэлийн засаг захиргааны байрууд, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авах ажлыг 2020 оны 04 дүгээр сард цахим хэлбэрээр зохион байгууллаа. Тус судалгаанд НЗЗ-ны байрууд болон НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа 517 ажилтан, албан хаагч хамрагдлаа. Судалгааны дүнгээс харахад манай байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд судалгаанд оролцогчдын 65% буюу дийлэнх хэсэг нь сайн үнэлгээ өгсөн ба төрийн албан хаагчдаас гаргасан санал, хүсэлтийг судлан үзэж, шийдвэрлэн ажиллах үүргийг холбогдох албан хаагчид өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.




График 6. Байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

### 3.2 НЗЗ-ны байруудын инженерийн байгууламжийн ашиглалт, ус, дулаан, цахилгаан, хурлын танхимуудын техник, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг ханган ажиллах чиглэлээр

ННҮГ-ын Байр ашиглалтын алба нь албаны дарга 1, инженер 3, нийт 47 хүний бүрэлдэхүүнтэйгээр НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ийн 4 салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн ус, дулаан, цахилгаан, мужааны засвар үйлчилгээ, инженерийн байгууламжийн хэвийн найдвартай, жигд ажиллагааг ханган ажиллаж, НЗЗ-ны 5-н байранд байрлан төрийн үйлчилгээ



үзүүлж буй Нийслэлийн нутгийн захиргааны 34 агентлагтай “Байр ашиглалтын гэрээ” болон “Гүйцэтгэх гэрээ” байгуулан гэрээний дагуу ажил, үйлчилгээг 24 цагаар тасралтгүй шуурхай үзүүлж ажиллаж байна.

Инженерийн шугам сүлжээг эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг албаны дарга сард 1 удаа, инженерүүд 14 хоног тутам тус тус тогтмол хийж, инженерийн байгууламжийн хэвийн ажиллагаанд хяналт тавьж, техникийн болзошгүй саатлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, НЗЗ-ны байруудын хаврын тохижилтийн ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан, хэрэгжилтийг ханган ажилласан.



Зураг 13. Гадна орчны аюулгүйн үзлэгийн үеэр

Төрийн албан хаагчдын амь нас, эрүүл мэнд, байгууллагын эд хөрөнгийг болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор байруудын галын буланг сэргээн засварлаж, иж бүрнээр тохижууллаа.



Зураг 14. Галын буланг тохижуулсан ажлаас

Тайлант хугацаанд инженерийн байгууламж, засвар үйлчилгээтэй холбоотой нийт 2694 дуудлагыг хүлээн авч шуурхай барагдуулан ажилласан ба 2019 онтой харьцуулахад 43%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь 2020 онд үзүүлсэн үйлчилгээний чанар сайжирсныг харуулсан эерэг үзүүлэлт гарч байна.



График 7. Тайлант хугацаанд БАА-нд ирсэн нийт дуудлага



График 8. Тайлант хугацаанд БАА-нд ирсэн нийт дуудлагыг харуулав


#### 3.2.1 Цахилгаан хангамжийн чиглэлээр:

НЗЗ-ны байруудын цахилгааны шугам сүлжээний хэвийн ажиллагааг хангах, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулж, цахилгаан ашиглалттай холбоотой 844 дуудлага ирснийг шуурхай засварлаж ажиллалаа.

НЗЗ-ны байруудын цахилгаан эрчим, хүчний аюулгүй байдлыг хангах, хэмнэлтийг бий болгох, цахилгааны хэвийн ажиллагааг хангах зорилгоор Зүүн Цахилгаан Түгээх салбартай хамтран ажиллах гэрээний дагуу тоолуур, гүйдлийн тр-р баталгаажуулах хуваарилах байгууламжуудын тоолуурыг шинээр сольж, ил гарсан цахилгааны болон, холбоо, сүлжээний утсыг далдалж аюулгүй байдлыг бүрэн ханган ажилласан.


Цахилгаан, эрчим хүчний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах зорилгоор 2020 онд зарим засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:

Тайлант хугацаанд УБЦТС болон Чингэлтэй эрчим хүчний газартай хамтран НЗЗ-ны 1, 2 дугаар байрны 123 ХТП, 2420 ХТП дэд станцын тоолуурыг бүрэн электрон тоолуураар сольж шинэчилсэн ба цахилгааны төлбөрийн бодит хэмнэлт хийх боломжтой болсон.



Зураг 15. Шинэчлэн сольсон тоолуур

НЗЗ-ны 3-р байрны цахилгааны засварын ажлыг “Дүүрэн гол” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу ерөнхий щитийг бүрэн тоноглож автоматжуулж, группийн щит, давхруудын хуваарилах самбаруудыг бүрэн шинэчилж, засварлуулан гүйцэтгэлийг хууль журмын дагуу хүлээн авч, цахилгаан, эрчим хүчний найдвартай жигд, хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.



Ерөнхий щитний байдал

Ерөнхий щитний ажлын дараах байдал

Зураг 16. НЗЗ-ны 3-р байрны ерөнхий щит

НЗЗ-ны 2 дугаар байрны нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө болон коридорын гэрлийг 5вт-ын лед гэрлээр шинэчлэн солилоо.

### 3.2.2 Сантехник, инженерийн шугам сүлжээний чиглэлээр:

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь тайлант хугацаанд НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн сантехникийн шугам сүлжээ, агааржуулалтын хоолойн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж, нийт 843 дуудлагыг бүртгэн шуурхай барагдуулж ажилласан бөгөөд 2019 оны 10-р сарын 01-ний өдрөөс 2020 оны 05-р сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд НЗЗ-ны байруудын халаалтын хэвийн ажиллагааг ханган ажиллалаа. Сантехник, инженерийн шугам, сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор зарим засварын ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал:

НЗЗ-ны байруудын хэрэгцээний халуун, хүйтэн усны Монгол улсын стандартад нийцэхгүй загварын тоолуурыг Монгол улсын стандарт хэмжил зүйн газраас баталгаажсан загварын тоолуураар сольж шинэчиллээ.



Зураг 17. Стандартын шаардлага хангасан халуун, хүйтэн усны тоолуур

НЗЗ-ны байруудын ашиглалтын шаардлага хангахгүй болсон шугам хоолойн холбох хэрэгсэл, хаалт, угаагуур, суултуурыг шинэчиллээ.



Зураг 18. Шугам хоолойн холбох хэрэгсэл, хаалт шинэчилж байгаа байдал



Зураг 19. Угаагуур сольж байгаа байдал

НЗЗ-ны 1-р байрны халаалтын хурдны ус халаагчийн цоорсон хоолойг хэсэгчлэн сольж хэрэглээний халуун усны автомат хаалт, мэдрэгчийг засварлаж хэвийн ажиллагааг хангасан. Мөн халаалтын 2-р хэлхээн дээр даралт хэмжигч шинээр тавьсан.



*Зураг 20. НЗЗ-ны 1-р байрны хурдны ус халаагчийн хэсэгчлэн сольж байгаа нь*



*Зураг 21. НЗЗ-ны 1-р байрны хэрэгцээний усны автомат хаалтыг засаж байгаа нь*




*Зураг 22. НЗЗ-ны 1-р байрны халаалтын хэлхээн дээр манометр тавьж байгаа нь*

Тус байрны 1-р давхрын ариун цэврийн өрөөний суултуурыг босоо шээлтүүр болгон шинэчиллээ.




*Зураг 23. Босоо шээлтүүр болгон шинэчилсэн байдал*

Мөн зоогийн газрын хэншүү сорогч хоолойг хатуу болон уян хоолой болгон шинээр сольж, агаарын хаялга хоолойд диффлектор тавьсан.



*Зураг 24. НЗЗ-ны 1-р байрны зоогийн газрын хэншүү сорох хоолойг шинэчилж байгаа байдал*

НЗЗ-ны 2-р байрны ариун цэврийн өрөөний эрэгтэй босоо шээлтүүрийн хэрэгцээний цэвэр усны ерөнхий босоо шугам хоолой зэвэрч муудсаныг шинээр сольж, давхар бүрт үзлэгийн тагийг шинээр тавьж, агааржуулалтын асуудлыг давхар шийдвэрлэлээ.



*Зураг 25. Босоо шугам ба хаалт*

НЗЗ-ны 2-р байрны 12-р давхарт халаалтын шугам хоолой шалан доор цоорсоныг ил шугам хоолой угсарч халаалтыг хэвийн ажиллагаанд оруулсан ба 1 давхрын операторууд байрладаг өрөөнд шинээр халаах хэрэгсэл суурилуулж өрөөг халаалттай болгосон.



*Зураг 26. НЗЗ-ны 2-р байрны 12 давхрын халаалтын цоорсон шугам хоолойг сольж байгаа нь*

Тус байрны 16 давхрын 2 ширхэг панелан радиотор нэмж суурилуулснаар тасалгааны температурыг хүйтний улиралд 15°C-20°C хооронд хэлбэлзэх хэмжээнд ойртууллаа.



*Зураг 27. НЗЗ-ны 2-р байрны 16 давхарт халаах хэрэгсэл шинээр суурилуулсан байдал*

Мөн хэрэгцээний зоорийн давхарт халуун усны ерөнхий шугам хоолой хагарсныг хэсэгчлэн сольж, хэвийн ажиллагааг ханган ажилласан.





*Зураг 28. НЗЗ-ны 2-р байрны хэрэгцээний халуун усны шугамын засварын явц*

Ариун цэврийн өрөөний агааржуулалтын хоолойн сорогчид сэнс тавьж соролтын хүчийг нэмэгдүүлсэн. Мөн зоогийн газрын халуун цехийн хэншүү сорогчийн сэнсийг шинэчилж, агааржуулалтын хэвийн ажиллагааг хангалаа.



*Зураг 29. Агааржуулалтын хоолойн сэнс*

Тус байрны хэрэгцээний хүйтэн усны насосны реле шатсаныг шинээр сольсон.



*Зураг 30. Хангарди ордны насосны релег сольж байгаа нь*

НЗЗ-ны 3-р байранд байрлах Чингэлтэй дүүрэг болон Берлин зоогийн газрын халаалтын буцах усны шугам хоолой зэвэрч муудан, цоорсон гэмтлийг олж тогтоон засварын ажлыг гүйцэтгэн хэвийн ажиллагааг хангасан байна.



*Зураг 31. НЗЗ-ны 3-р байрны халаалтын буцах шугамын засварын ажил*

НЗЗ-ны 4-р байрны халаалтын ерөнхий шугамд таслах хаалт, халаалтын автомат хаалт, хуваарилах коллекторын таслах хаалтуудыг шинэчилсэн.



*Зураг 32. НЗЗ-ны 4-р байрны халаалтын ерөнхий коллекторын хаалтыг шинэчилсэн нь*

НЗЗ-ны 5-р байрны гадна шугамын 150 м зайд 125Ф хүйтэн усны шугамын хөрс хуулж, сувагт шинээр сольж, стандартын дагуу дулаалах, худагт 125Ф таслах хаалт байрлуулах, барилга доторх 150м ерөнхий шугамын 125Ф-176Ф диаметртэй хэсэгт хөдлөх болон үл хөдлөх тулгуурын бэхэлгээг бүхэлд нь шалгаж, эвдэрч гэмтсэн хэсгийг шинэчлэн, таслах хаалт, тоолуур, даралт мэдрэгч, даралтын заалт зэргийг стандартын дагуу байршуулах ажлыг “Эрдэнэ талст инженеринг” ХХК-р хийж гүйцэтгүүлэн хүлээн авч, шугам хоолойн хэвийн найдвартай, жигд ажиллагааг ханган ажиллалаа.



*Зураг 33. НЗЗ-ны 5 дугаар байрны гадна шугам, хоолойн засвар*

НЗЗ-ны 5 байрны ариун цэврийн өрөөнд хэрэгцээний халуун ус шинээр татаж оруулан, хүйтэн ус болон хэрэгцээний халуун усны ерөнхий шугамд хаалт тавьсан.



*Зураг 34. НЗЗ-ны 5в-р байрны хэрэгцээний усны ерөнхий шугамыг сольж байгаа нь*

3.2.3. НЗЗ-ны байруудын хурлын танхим, хяналтын камеруудын техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангах чиглэлээр

Байруудын хяналтын камерийн хэвийн ажиллагаан хангах зорилгоор тайлант хугацаанд 26 ширхэг камер, 3 ширхэг тог бууруулагч, 3 ширхэг NVR, 1 ширхэг хатуу диск, 1 ширхэг тэжээлийн блокийг тус тус сольж, засварлаж, хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.

2020 онд НИТХ 10 удаа НЗД-н шуурхай 7, НЗД-ын зөвлөлийн хурал 14, НЗАА шуурхай 6, бусад хурал 346 удаа болсон байна. Эдгээр хурлуудын тоног төхөөрөмжийн бэлтгэл ажлыг хангаж ямар нэгэн доголдолгүй хэвийн явуулах нөхцөлийг бүрэн хангаж ажиллалаа.

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын [www.Khangardi.mn](http://www.Khangardi.mn) цахим хуудсыг хөтлөлт, хөгжүүлэлтийг тухай бүр нь хийж, мэдээллийн болон техникийн аюулгүй байдлын ханган ажиллаж, аливаа цахим халдлагаас урьдчилан сэргийлж ажилласан байна.

Мэдээллийн аюулгүй байдлын хангах чиглэлээр захиргааны албан хаагчдын 15 ширхэг ширээний компьютерт SSD хатуу диск болон ddr3-4gb рам нэмж суулган өргөтгөл хийсэн. Мөн “Үндэсний дата төв” УТҮГ-тай гэрээ хийж, захиргааны 22 албан хаагчид E-TOKEN буюу тоон гарын үсэг хүлээлгэн өглөө.

3.2.4. НЗЗ-ны байруудын хүн зөөврийн цахилгаан шатны хэвийн ажиллагааг хангах чиглэлээр

Тайлант хугацаанд НЗЗ-ны 2, 4 дүгээр байруудын хүн зөөврийн болон ачааны 6 ширхэг цахилгаан шатны ашиглалт, засвар үйлчилгээг сар бүр гэрээт байгууллагаар гүйцэтгүүлж, албан хаагчид болон иргэдийг аюулгүй тээвэрлэх ажил үүргээ гүйцэтгэж ажиллалаа. НЗЗ-ны 2-р байрны цахилгаан шатны ган татлага буюу гинжийг гэрээт байгууллагаар солиулсан.

3.2.5. НЗЗ-ны байруудын засвар үйлчилгээний чиглэлээр

НЗЗ-ны 2-р байр буюу Хангарди ордны 1600м2 талбай бүхий урд, хойд хэсгийн дээвэр, дээврийн шилэн фасадны засварын ажлыг “Товруу Сүмбэр” ХХК-р гүйцэтгүүлж, ажлын хэсэг байгуулан хүлээж авсан.



Зураг 35. Дээврийн засварын ажил

НЗДТГ-ын төв хаалганы нэвтрэн шалгах хаалга буюу металл илрүүлэгч хаалгыг суурилуулах ажлыг “Нано Планет” ХХК-иар гүйцэтгүүлэн, хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.



Зураг 36. Металл илрүүлэгч хаалга



“Нэг хот нэг стандарт” зорилтод жилийн хүрээнд НЗЗ-ны 2 дугаар байрны ариун цэврийн өрөөнүүдийг стандартын дагуу тохижуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж, тайлант хугацаанд 5 дугаар давхрын ариун цэврийн өрөөг тохижууллаа.



Зураг 37. Тохижуулсан ариун цэврийн өрөө

Зорилтот жилийн хүрээнд хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах зорилгоор Баянхошуу дэд төвийн гадна талбайд ангилан ялгах зориулалт бүхий хогийн савыг хийж гүйцэтгэлээ.




Зураг 38. Ангилан ялгах зориулалт бүхий хогийн зав

Мөн тайлант хугацаанд НЗЗ-ны байруудын нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, засвар, арчилгаа, үйлчилгээг өдөр тутам гүйцэтгэн ажиллалаа.




Зураг 39. Засвар үйлчилгээ хийх үер

НЗЗ-ны 4 дүгээр байр: Аваарын шатны бариул бэхэлгээг гагнаж хүн унаж гэмтэхээс хамгаалж хэвийн болгов.



Зураг 40. НЗЗ-ны 4-р байрны шатны засвар

НЗЗ-ны 5 дугаар байр: 5 байрны нийтийн эзэмшлийн талбайг Нэг хот Нэг стандартын дагуу засаж янзлав. Уг хана нь мөөгөнцөртөж муудсан хананы шавар нь нурсан байсан.



Зураг 41. НЗЗ-ны 5-р байрны хананд засвар хийсэн байдал

### 3.3. Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, эрүүл ахуйд нийцсэн зоогийн үйлчилгээ, хурлын заалны ашиглалт, үйлчилгээний чиглэлээр

#### 3.3.1 Нийслэлийн Засаг захиргааны байруудын цэвэрлэгээ үйлчилгээ

Өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд байгууллагад мөрдөгдөж буй цэвэрлэгээ үйлчилгээний стандартын эмхтгэлийг боловсронгуй болгон “Нутгийн захиргааны байгууллагуудын цэвэрлэгээ, үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” болгон өөрчилж, Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газраас баталгаажуулах код авсан ба өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээндээ мөрдөн ажиллаж байна.

НЗЗ-ны 5-н байр, ННҮТөвийн 4 салбарын нийт 42009.1м.кв талбайн өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлж, цэвэрлэгээний давтамжийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан 2 цаг тутамд ариутгалын бодистой чийгтэй цэвэрлэгээг хийж, ажлын байранд агаар сэлгэлт тогтмол хийн, спиртэн суурьтай гар ариутгагч уусмалыг хэрэглэж, цэвэрлэх үйлчилгээг 125 үйлчилгээний ажилтан албан хаагчид хийж гүйцэтгэсэн. Байгууллагын цахим хуудсанд өдөр бүр ажлын үйл явц байдлыг байршуулан, ажлын гүйцэтгэлд байр хариуцсан менежерүүд давхар хяналт тавьж хэрэгжилтийг ханган ажилласан. Жилийн эцсийн байдлаар 528 удаа цэвэрлэгээ үйлчилгээ үзүүлсэн.





Зураг 42. Цэвэрлэгээ, үйлчилгээ хийж буй байдал



График 9. Нийт талбай ба үйлчлүүлэгчдийн тоон үзүүлэлтийг графикаар үзүүлбэл

2019 онд үйлчлэгчийн тоо 122, НЗЗ-ны байруудын нийт талбайн хэмжээ 39.176 мк.в байсан бол 2020 онд үйлчлэгчийн тоо 127 болж, НЗЗ-ны байруудын нийт талбайн хэмжээ 424951,1мкв болж нэмэгдсэн нь Баянхошуу, Сэлбэ дэд төвүүд, И мартын салбарын ашиглалтыг хариуцан ажиллаж байгаатай холбоотой юм.

Мөн НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах дадлыг хэвшүүлэх ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулах ажлын хүрээнд ангилан ялгах хогийн савыг НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдэд байршуулах ажлыг зохион байгуулсан ба хог ангилан ялгах ажлыг хэвшүүлээд байна. "Хог, хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах" сэдэвт сургалтыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран НЗЗ-ны байрууд, НҮНТөвийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын болон аж ахуй нэгж, байгууллагын 94 ажилтан, албан хаагч, ННҮГазраас нийт 130 ажилтан, албан хаагч хамрагдлаа. Мөн "Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах" чиглэлээр байгууллагын "Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар" пэйж хуудас, [www.Khangardi.mn](http://www.Khangardi.mn) цахим хуудсуудаар дамжуулан иргэд олон нийтэд сурталчлах, нөлөөллийн ажлуудыг хийж ажилласан байна.



Зураг 43. Хог ангилан ялгах хогийн савыг нийтийн эзэмшлийн талбайд байршуулсан байдал

Үйлчилгээний ажилтнуудад 125 ш хувцас, ажлын багаж хэрэглэлийг шинэчилж бүрэн хангасан. Гадна талбайн үйлчилгээний ажилчдын өвлийн хувцсыг хийлгэх ажлыг судалж, нийт 12 ажилтны хувцсыг хөдөлмөр аюулгүй байдлын стандартад нийцсэн өвлийн дулаан хувцсаар бүрэн хангасан.



Зураг 44. Үйлчлэгчийн өдөр тутмын ажлын хувцас болон гадна талбайн үйлчлэгчийн өвлийн ажлын хувцас

#### Байруудын гадна орчны цэвэрлэгээ үйлчилгээний талаар

НЗЗ-ны байрууд гаднах орчны аюулгүй байдлыг ханган өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэн тухайн байруудын гаднах нийтийн эзэмшлийн зам талбайг халтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлж, орчны 50 метр хүртэлх талбайн цас, мөс цэвэрлэх ажлыг 11 удаа 24.450мкв талбайд, өдөр тутмын цэвэрлэгээг 124 удаа, дээврийн цэвэрлэгээг 5 удаа тус тус хийж, жилийн эцсийн байдлаар нийт 140 удаа гадна талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаа.



Зураг 40. Цас цэвэрлэгээний үер



Зураг 45. Гадна талбайн цэвэрлэгээний үеэр

#### Ариутгал халдваргүйжүүлэлтийн талаар

НЗЗ-ны 2, 3, 4, 5-р байрны А, Б, В корпусын нийтийн эзэмшлийн талбай, НЗЗ-ны 1, 2, 5А байрны зоогийн газрын нийт 10.564.62 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйжүүлэлт, хортон

шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийг ажил гүйцэтгэх гэрээний дагуу “Түвшин төгөлдөр”ХХК-тай 10 удаа хамтран ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлээ. Хүний гар их хүрэх боломжит гадаргуу, ариун цэврийн өрөөг 2 цаг тутамд жавелин болон хлорсевтийн 0.06% уусмалаар ариутган халдваргүйжүүлж байна.

Гарагийн 7 хоногийн 5 дахь өдөр бүр албан тасалгаа болон нийтийн эзэмшлийн коридор, ариун цэврийн өрөөнүүдийн нийт 9549,6 м.кв талбайг халдваргүйжүүлэлтийг мананцраар шүрших төхөөрөмжөөр тогтмол ариутгал хийж ажиллаа.

Тайлант хугацаанд “Хангарьд” зоогийн газарт 10 удаа шавьжгүйтгэл болон ариутгал, халдваргүйжуулалт хийж, 4 удаа тандалт хийлгэж ажиллалаа.

Халдвар хамгааллын дэглэмийн үед НЗЗ-ны байруудад ариутгалын гар ажиллагаатай төхөөрөмж 4 ширхэг, агаарт мананцар шүршигч төхөөрөмж 4 ширхэг, хөлөөр гишгэгч гар ариутгалын төхөөрөмж 5 ширхгийг шинээр авч байршуулсан.



Зураг 46. НЗЗ-ны байрууд, ННҮТөвүүдэд ариутгал халдваргүйжүүлэлт

Ариутгал халдваргүйжүүлэлтийг улирлаар харьцуулбал:



График 10. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийгдсэнийг улирлаар харьцуулсан байдал

## Тохижилт, үйлчилгээний талаар

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллахын зэрэгцээ төрийн албан хаагчдын ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр байруудын гадна болон дотор талын тохижилтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

“Хотын соёл” аяны хүрээнд НЗЗ-ны байрууд, ННҮТөвийн салбарын ажилтан, албан хаагчид гадна болон дотор тохижилт, шинэлэг, сэргээн засварлах, засвар үйлчилгээнд баг хамт олноороо идэвхтэй оролцож, НЗЗ-ны 2-р байрны “Хамтдаа, Эрч хүч, Эвсэг” гурван багийн хамт олон “Соёлтой цэвэр орчин бүрдүүлцгээе” их цэвэрлэгээний аян өрнүүлээ.

НЗЗ-ны байруудын гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлж орчны тохижилтыг сайжруулах зорилгоор НЗЗ-ны байруудын гадна талбайд цэцгийн мандал, үрсэлгээг хийлээ.



Зураг 47. Ногоон байгууламж, гадна тохижилтоор хийгдсэн ажлуудаас

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан хаврын тохижилтын ажлыг зохион байгуулж 2020.05.08 наас 2020.05.12 ны өдрүүдэд НЗЗ-ны 5 байр, НҮНТ-ын 4 төвүүдийн ажилтан, албан хаагчид тухайн байр бүрийн гадна талбайд мод тарих, зүлэгжүүлэх, цэцгийн үр суулгаж услах, орчны хайс, цэцгийн мандлыг будах зэрэг гадна орчны тохижилтын ажлыг хийхэд үйлчилгээний ажилтнууд идэвхтэй оролцлоо.

“Шарилжгүй Улаанбаатар” аянтай холбогдуулан төрийн албан хаагчид болон иргэдийг шарилжаас үүдэлтэй харшлын эмгэгээс хамгаалах үүднээс байруудын нийтийн эзэмшлийн талбайд ургасан шарилж, лууль, зэрлэг ургамлыг цэвэрлэж устгах ажлыг хийж гүйцэтгэсэн.

### 3.3.2 Хоол, цай, зоогийн үйлчилгээ

Хангарди ордны зоогийн газар, НЗДТГ, Улаанбаатар чуулгын цайны газруудаар нийтийн хоол, хүндэтгэлийн хүлээн авалт, цай завсарлага, катеринг үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллаж байна.

Эрүүл чанартай хоол хүнс бэлтгэх, хүнсний бараа материалыг гэрээний дагуу худалдан авахдаа эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийн бичиг, шинжилгээний бичгийн хамт хүлээн авдаг ба хадгалалтын горимд “Хоолны газрын нийтлэг журам”-ыг мөрдөн ажиллаж, зоогийн газар, цайны газруудын ажилтнуудыг ХУД-н Эрүүл мэндийн төв, ЧД-ийн Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тогтмол хамруулан хоол хүнсний эрүүл ахуйг хангаж ажилласан. Мөн ЧД-ийн Мэргэжлийн хяналтын хэлтэст хүсэлт гарган НЗЗ-ны 1, 2, 5 дугаар байруудын зоогийн газрын ундны усны шинжилгээг өгч, шинжилгээгээр ундны усны хэрэглээг бүрэн хангасан дүгнэлт гарсан.


Зоогийн газарт тавигдах зоогийн газрын ажилчдын өдөр тутмын хувийн ариун цэвэр, хөргөгч хөлдөөгчний температурын хяналт зэрэг 9 төрлийн бүртгэл хөтлөлтийг тогтмол хөтөлж, хэрэгжүүлэн ажилласан.

Мөн 3-н байранд байрлах зоогийн газрын кассын машиныг НӨАТ-ын буцаалтын QR код, сугалааны дугаартай баримт хэвлэдэг дэвшилтэт иж бүрдэлээр тоног төхөөрөмжөөр шинэчлэн суурилуулж, үйлчилгээнд нэвтрүүлсэн.



Зураг 48. Кассын машины шинэ төхөөрөмж

Хангарьд ордны 15 давхарт байрлах кофе шопийн үйлчилгээг дахин идэвхтэй үйл ажиллагаанд оруулж, бүтээгдэхүүний төрөлжилтийг нэмэгдүүлж зурагт цэсээр үйлчилдэг болсон.



Зураг 49. Кофе шопын үйл ажиллагаа

Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас хэрэгжүүлж буй хүнсний хог хаягдлаар бордоо хийх төслийн хүрээнд зоогийн газрын хүнсний ногоо, жимсний хальс, хоолны үлдэгдэл, хэрэглэсэн хүнсний тос, амны цаас, чигчлүүр зэрэг хаягдлыг ангилан ялгаж, Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээ ХХК-д нийлүүлэн ажиллаж байна.



Зураг 50. Хоолны хог хаягдлыг ангилан, ачилтын машинд нийлүүлж буй явц

Зоогийн газрын ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлын чанарын шаардлага хангасан иж бүрэн өдөр тутмын хувцсаар хангалаа.

Зоогийн газрын ажилтнуудыг хөдөлмөрийн аюулгүй байдлын чанарын шаардлагад нийцсэн хүндэтгэлийн зоогийн үйлчилгээнд 18ш, өдөр тутмын үйл ажиллагаанд 20ш иж бүрэн хувцсаар жигдрүүлсэн. Мөн зоогийн үйлчилгээний зөөгч нарын өдөр тутмын болон хүндэтгэлийн хувцасыг хийлгэх, жигдрүүлэх ажлыг судлан үе шатандаа явж байна.



Зураг 51. Зоогийн газрын ажилтнууд

Нийтийн хоолны үйлчилгээний талаар:

Хангардийн зоогийн газар дунджаар 16.542 хүн, НЗДТГ-ын цайны газарт 13.200 хүн, НЗЗ-ны 5-р байрны цайны газар 1200 орчим албан хаагчдад болон катерингийн үйлчилгээгээр 658 буюу нийт 31,600 орчим хүнд халуун хоол, цайны үйлчилгээг тус тус үзүүлэн ажиллалаа.

Өдөр тутмын хоолны цэсийг улирлын онцлогт тохируулан шинэчлэн, Хангарди ордны зоогийн газрын хоолны цэсэд нэгдүгээр хоолны 5, хоёрдугаар хоолны 10, зууш салатны 6, ЗДТГ-ын цайны сувиллын хоолны цэсийг тус тус шинэчлэн батлуулж үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.

Зоогийн газраас гарч буй бүтээгдэхүүний хоолны сав, баглаа боодлыг стандартын шаардлага хангасан материалаар хийсэн хэрэглэгдэхүүн хэрэглэж, хүлээн авалтын ширээ засалт түүнд хэрэглэгдэх зүйлсийн жагсаалт гаргаж зарим зүйлсийг үе шаттайгаар худалдан авч, хоол үйлдвэрлэлд хэрэглэгдэж буй түүхий эдийн чанарт анхаарч, хадгалалтын горимыг мөрдүүлэн ажиллаж, шаардлагатай эд зүйлсийг нэмэгдүүлэн ажилласан.



График 11. 2020 оны зоогийн газруудын орлогын харьцуулалт



График 12. Сүүлийн 3 жилийн орлогын харьцуулбал

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж төвлөрүүлсэн орлогын хэмжээ өмнөх оныхоос 87%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Хүлээн авалтын үйлчилгээний талаар:

Тайлант хугацаанд Тулгар төрийн 2229, Их Монгол Улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлыг хангаж, Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт байрлах “Арван гурав дугаар зуун цогцолбор”-т, Хүй 7 худагт баярын хүндэтгэлийн хүлээн авалтын бэлтгэл ажлыг хангаж, хоол, зоогийн үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлж ажилласан.





*Зураг 52. Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд хээрийн зоогийн үйлчилгээ үзүүлэв*

Монгол Улсын нийслэл үүсэн байгуулагдсаны түүхт 381 жилийн ойг тохиолдуулан Нийслэлийн удирдлагууд нийслэлийн анхны шавыг тавьсан газар буюу Өвөрхангай аймгийн Бүрд сумын гуравдугаар багийн нутаг Их Монгол уулын бэл, Ширээт цагаан нуурын хөвөөнд орших гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээний үеэр нийслэл, орон нутгийн удирдлагууд болон хүрэлцэн ирсэн зочид, нутгийн иргэдэд хүндэтгэлийн болон хээрийн хүлээн авалтын үйлчилгээг амжилттай зохион байгуулан ажилласан.



*Зураг 53. Гэрэлт хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд хээрийн зоогийн үйлчилгээний үеэр*

Мөн Нийслэлийн 381 жилийн ойн Хүндэтгэлийн концерт, Нийслэлийн 381 жилийн ойд зориулсан бөхийн барилдаан, Хүндэтгэлийн зоог зэрэг арга хэмжээнд Нийслэлийн удирдлагууд болон зочид төлөөлөгчид, тамирчдад VIP болон зоогийн үйлчилгээг үйлчилгээний өндөр түвшинд үзүүлж ажиллалаа.



*Зураг 54. Баярын арга хэмжээнүүдэд зоогийн үйлчилгээ үзүүлэв*

2020 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр төрийн тахилгат Богдхан уулын тэнгэрийг тайх ёслолын үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангаж, 300 гаруй зочид, төлөөлөгчдөд хээрийн нөхцөлд эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хүнсээр бэлтгэж, хүндэтгэлийн зоогийн үйлчилгээг мэргэжлийн өндөр төвшинд түргэн шуурхай үзүүлж ажиллалаа.



Зураг 55. Тахилгын үйл ажиллагааны явцаас

Тайлант хугацаанд заалаар үйлчлэх зоогийн хүлээн авалтыг 10 удаа, цай завсарлагын үйлчилгээг 3 удаа, хээрийн болон зөөврийн үйлчилгээг 9 удаа, боолтын хоол үйлчилгээг 7 удаа тус тус үзүүлсэн байна.



Зураг 56. Зөөврийн хоол

### 3.3.3 Хурлын заалны ашиглалт, үйлчилгээний чиглэлээр:

Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор Нийслэлийн Засаг Захиргааны байруудын хурлын заал танхимд Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах хурал, зөвлөгөөний тоо буурч цаг үеийн нөхцөл байдалд тодорхой зарлагдсан хурлууд хийгдлээ.

Хуралдааны танхимд явагдах арга хэмжээний захиалгыг урьдчилан авч, график хуваарьт оруулан, хуваарийн дагуу хөнгөн шуурхай, чанартай үйлчилгээ үзүүлж ажилласан. 2020 оны байдлаар Хангарди ордны хурлын танхимуудад нийт 416 удаагийн үйл ажиллагаа хүлээн авч, давхардсан тоогоор 9100 хүнд хурлын үйлчилгээг үзүүлсэн байна.

Хүснэгт 7

| №   | Хурлын чиглэл              | Хуралдсан тоо |
|---|----------------------------|---------------|
| <b>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар</b>           |                            |               |
| 1.  | Удирдлагын зөвлөлийн хурал | 14 удаа       |
| 2.  | Нийслэлийн шуурхай         | 8 удаа        |
| 3.  | ЗАА шуурхай                | 6 удаа        |
| 4.  | Бусад                      | 346 удаа      |
| 5.  | Цайны завсарлага           | 19 удаа       |
| 6.  | Шагнал                     | 5 удаа        |
| <b>Нийслэлийн Иргэдийн Хурлын төлөөлөгчдийн хурал</b> |                            |               |
| 7.  | НИТХ-ын чуулган            | 9 удаа        |
| <b>Онцгой комисс</b>                                  |                            |               |
| 8.  | Онцгой комисс              | 9 удаа        |
|   | Нийт                       | 416           |

## 2020 он улирлаар харьцуулбал

|                       | 1 улирал | 2 улирал | 3 улирал | 4 улирал |
|-----------------------|----------|----------|----------|----------|
| ■ Засаг даргын зөвлөл | 4        | 5        | 2        | 3        |
| ■ Нийслэл шуурхай     | 5        | 1        | 1        | 1        |
| ■ ЗАА шуурхай         | 4        |          |          | 2        |
| ■ НИТХ чуулган        | 2        | 2        | 2        | 3        |
| ■ Цай завсарлага      | 4        | 2        | 8        | 5        |
| ■ Онцгой комисс       | 6        | 2        |          | 1        |
| ■ Бусад               | 101      | 95       | 70       | 85       |
| ■ Нийт                | 126      | 107      | 83       | 100      |

График 13. Хангаарди ордны хурлын үйл ажиллагааг улирлаар харьцуулбал:

Хурлын цай завсарлага үйлчилгээ:

Хурлын цай завсарлагын үйлчилгээг стандартын дагуу эрүүл ахуйн найдвартай баталгаатай хүнсээр хангасан цайны завсарлагаа, кофе брекний үйлчилгээг сүүлийн хагас жилийн байдлаар 19 удаа 570 хүнд үйл ажиллагааны бэлтгэл ажлыг бүрэн хангаж, шуурхай чанартай үзүүлсэн.



Зураг 57. Хурлын цай завсарлагын үйлчилгээ

ЗДТГ-ын хурлын танхимуудад: А танхимд 288 хурал, Б танхимд 88 уулзалт, VIP танхимд 61 уулзалт шагнал гардуулах үйл ажиллагаа, Тэргүүлэгчдийн хурал 24 удаа болж сүүлийн хагас жилийн байдлаар нийт 461 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулагдсан. Н33-ны 5 дугаар байрны Б хэсгийн хурлын танхимд: эвент арга хэмжээ-40, сургалт-8, шалгалт-7, төслийн нээлт-2 нийт 57 үйл ажиллагаа зохион байгуулагдсан.

Н33-ны 5 дугаар байрны В хэсгийн Иргэний танхимд: сургалт-10, тэмцээн-1, хурал-3, өдөрлөг-3, баярын арга хэмжээ-2, дуудлага худалдаа-1 нийт 20 үйл ажиллагаа зохион байгуулагдсан. Жилийн эцсийн байдлаар нийт 949 удаагийн хурлын заал, танхимуудын захиалгыг хүлээн авч, үйлчилгээний бэлтгэл ажлыг бүрэн хангаж, ямар нэгэн зөрчил, доголдолгүй үйлчилгээг үзүүлж ажиллалаа.




График 14. ЗДТГ-ын хурлын танхимуудын үйл ажиллагааг графикаар харьцуулбал



График 15. Нийт хурлын үйл ажиллагааг харьцуулсан байдал

ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН  
2020 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ

Хүснэгт 8

| Зорилт                        | № | Үйл ажиллагаа   | Шалгуур үзүүлэлт     | Зорилтот түвшин (Тоо хэмжээ, хувь) | Хүрсэн түвшин (Хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ) | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг) | Тайлбар   |
|-------------------------------|---|---|----------------------|------------------------------------|---|--|---|
| 1. Хүний нөөцийг чадавхжуулах | 1 | Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт | Дотоод сургалтын тоо | 5-аас дээш                         | 10 удаа                                       | 350 000₮   | <p>- Тайлант хугацаанд захиргаа, санхүүгийн хэлтсээс нягтлан бодох бүртгэл мэргэжлээр 2, бизнесийн удирдлагын магистраар 1 албан хаагч тус тус суралцаж төгслөө. Мөн Хүмүүнлэгийн Ухааны их сургуульд хэл шинжлэлийн магистрантур, Олон улсын Улаанбаатар их сургуульд эрх зүйн магистрантур, ХААИС-ийн газар зохион байгуулалтын мэргэжлээр, Хөдөлмөр нийгмийн хамгааллын дээд сургуулийн ХАБЭА бакалавраар тус тус суралцаж байна.</p> <p>- Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/590 дугаар захирамжаар зарим сургалтын үйл ажиллагааны хязгаарлалтыг цуцалсны дагуу дараах сургалтыг зохион байгууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Удирдлагын академийн багш, доктор М.Амартүвшинг урин 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр "Гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээ, тайлагналтыг боловсруулах аргачлал" сэдэвт сургалтыг захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагч 45;</li> <li>2020 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Хог хаягдлын менежмент, сэргээгдэх эрчим хүч, ногоон байгууламжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төслүүдийн удирдагч Б.Шижирбатыг урин "Цэцэрхүүлэлт хийх, цэцэг, ногоон байгууламжийг арчлах" сэдвээр үйлчилгээний албаны багийн ахлагч 15;</li> <li>Удирдлагын академийн багш, Доктор Д.Мөнхчулуун(Ph.D)-ыг урин "Төрийн албан хаагчийн манлайлал, харилцааны ур чадвар, ёс зүй, имидж бүрдүүлэлт" сэдвээр 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчид - 40;</li> <li>Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэгийг нэмэгдүүлэх, дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор НЗЗ-ны 5 байр, НҮНТөвийн 4 салбар, Баянхошуу дэд төв "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн" зааварчилгааг байр тус бүрийн онцлог, нөхцөл байдалд тохируулан бэлтгэн ажилчдад онол, дадлага хэлбэрээр 167 ажилтанд сургалтыг тус тус зохион</li> </ul> |
|                               |   |   |                      |                                    |   | 200 000₮   |   |

|  |  |          |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |
|--|--|----------|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| <p>байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мөн 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн Монголын хүний нөөцийн институтийн Хүний нөөцийн мэргэшүүлэх онлайн сургалтад 14 хоногийн 60 академик цагийн сургалтад 2 албан хаагчийг хамрууллаа.</li> </ul>   |  | 400 000₮ |  |  |  |  |  |  |  |  |  |  | <ul style="list-style-type: none"> <li>• Сангийн яамнаас төрийн албаны цалингийн нэгдсэн систем (ТАЦНС)-ийг цалин хөлсний төлөвлөлт, гүйцэтгэл хяналтыг сайжруулах, автоматжуулах, нягтлан бодогчдод ТАХ-ын хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, суутгалын тооцооллыг бодитой тооцоход ХНУС болон ТАЦНС сургалт-семинарыг 2020 оны 08 дугаар сарын 10-14-ний өдрүүдэд танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулсан. Тус сургалтад ерөнхий нягтлан бодогч, агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогчид, тооцооны нягтлан бодогчид болон хүний нөөцийн ажилтнууд нийт 12 албан хаагч тус тус хамрагдсан.</li> </ul> |
| <ul style="list-style-type: none"> <li>• Монголын ариутгал халдваргүйжүүлэлтийн холбоо ТББ-ын тэргүүн Н.Баасанжав ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, төхөөрөмжийг хэрхэн ашиглаж хэрэглэх, ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр "Коронавирус халдварын сэргийлэлт, хяналт" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад байгууллагын удирдлагууд, байр хариуцсан менежерүүд болон үйдчилгээний ажилчид, нийт 35 ажилтан, албан хаагч хамрагдсан.</li> </ul> |  |          |  |  |  |  |  |  |  |  |  | <ul style="list-style-type: none"> <li>• Монголын Хуульчдын холбооноос хуульчдын мэдлэг, мэргэшлийн түвшин, ур чадварыг эрх зүйн онолын орчин үеийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэл, шүүх эрх мэдлийн байгууллагын хөгжлийн шаардлагад нийцүүлэн тогтмол дээшлүүлэх, мэргэжлийн ёс зүйг чанд мөрдөж, шударга, хараат бусаар ажиллах чадварыг төлөвшүүлэх чиглэлээр 2020 оны 09 дүгээр сарын 09-12-ны өдрүүдийн хугацаанд зохион байгуулсан "Хуульчийн кредит цагийн багц сургалт"-д хууль эрх зүй-Тогтоол шийдвэрийн хэрэгжилт хариуцсан ажилтан Э.Хорогдуламыг хамруулсан.</li> </ul> |  |
|  |  |          |  |  |  |  |  |  |  |  |  | <ul style="list-style-type: none"> <li>• Дэлхийн Аялал Жуулчлалын өдрийг угтан Аялал, жуулчлалын яам, Зочлох Үйлчлэх Салбарын Сургалт Хөгжлийн төвтэй хамтран "Нөгсө Mongolia conference" чуулга уулзалтыг "Борлуулалтаа удирдах нь" сэдвийн хүрээнд 2020 оны 9-р сарын 26-ны өдөр зоогийн газрын менежер Б.Эрдэнэтөгс, хурлын заалны зохион байгуулагч Б.Энхбилэгт нар хамрагдсан.</li> </ul>   |  |
|  |  |          |  |  |  |  |  |  |  |  |  | <ul style="list-style-type: none"> <li>• "Чанарын удирдлагын менежментийн тоглоцоо /ISO9001/" олон улсын стандартыг байгууллагын үйл ажиллагаанд 3-н үе шаттайгаар хэрэгжүүлэн нэвтрүүлэх ажлыг эхлүүлж эхний үе шат буюу</li> </ul>   |  |

|  |  |   |                |                          |  |  |  |  |
|--|--|---|----------------|--------------------------|--|--|--|--|
|  |  |   |                |                          |  |  |  | байгууллагын чанарын багийг сургах ажлыг эхлүүлэн Удирдлагын академийн багш Ц.Өнөржаргалыг 2020 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр чанарын удирдлагын тогтолцоо ISO9001 стандартыг нэвтрүүлэхэд юуг анхаарах, хэрхэн, яаж нэвтрүүлэх зэрэг мэргэжил, онол арга зүйн сургалтыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн 13 албан хаагчдад зохион байгуулсан.   |
|  |  |   | 80 хувиас дээш | 100 %                    |  |  |  | - Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх сургалтад давхардсан тоогоор 332 ажилтан албан хаагчид хамрагдсан байна<br>- Захиргаа, санхүүгийн хэлтсийн 3-н албан хаагч хувийн зардлаараа нягтлан бодох бүртгэл мэргэжлээр -2, бизнесийн удирдлагын магистр-1 тус тус суралцаж амжилттай төгссөн.<br>- Хүмүүнлэгийн Ухааны их сургуульд хэл шинжлэлийн магистрантур, Олон улсын Улаанбаатар их сургуульд эрх зүйн магистрантур, Хөдөлмөр нийгмийн хамгааллын дээд сургуулийн ХАБЭА бакалавраар , ХААИС-ийн газар зохион байгуулалтын мэргэжлээр нийт 4 албан хаагч хувийн зардлаараа суралцаж байна.                    |
|  |  | Албан хаагчдын хамрагдсан байдал                                      |                |                          |  |  |  |  |
|  |  | Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал                     |                |                          |  |  |  |  |
| 2  | Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх         | 3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт | 70 хувиас дээш | 80%                      |  |  |  | - Тус байгууллага нь олон чиглэлийн үйлчилгээг эрхэлдэг тул олон мэргэжлийн ажилтан албан хаагчид байдаг. Одоогийн байдлаар мэргэшсэн нягтлан бодогч 2, ахлах зэрэгтэй эмч 1, Зоогийн газарт 1-3 дугаар зэрэгтэй тогооч 12, 3-р зэрэгтэй үйлчилгээний ажилтан 20 ажиллаж байна. 300 ажилтан, албан хаагчдын 80 хувь нь 3 болон түүнээс дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байна.   |
| <b>Хэсгийн дундаж 93,3 % 1 470 000 ₮</b>   |  |   |                |                          |  |  |  |  |
| 2.Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын Тоо                     | Гүйцэтгэл-ээр  | 327 ажилтан, албан хаагч |  |  |  | - Дэлхий нийтэд коронавируст /Covid-19/ халдварт өвчин дэгдэж улс даяар өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан тус газрын нийт ажилтан, албан хаагчид 02 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдөр хүртэлх хугацаанд Хан-Уул дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл мэндийг халдварт өвчнөөс хамгаалах, аюулгүй байдлыг сахиулж заавар зөвлөмж өгөн ажилласан билээ. Энэхүү ажилд идэвх санаачлагатай ажилласан 257 албан хаагчдад НЗД-ын А/342 дугаар захирамжийн хүрээнд 85 900 000 төг, НЗД-ын А/747 дүгээр захирамжийн хүрээнд 34 494 812 төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус 2 удаа олгон ажилласан. |
|  |  |   |                |                          |  |  |  | -Ажилтан албан хаагчдын ажлыг улирлаар дүгнэн давхардан тоогоор 327 ажилтан, албан хаагчдад 272 623 426 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгож ажиллалаа.   |

|   |  |   |   |                                 |                                 |   |   |
|---|--|---|---|---------------------------------|---------------------------------|---|---|
|   |  |   | Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал, ахиулах | Гүйцэтгэл-ээр                   | 327 ажилтан албан хаагч<br>100% | 329 843 861₮  | 2020 онд давхардсан тоогоор 327 ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдэлд 329 843 861 төгрөгийг зарцуулсан байна.   |
| 4 | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга      | Сэтгэл ханамж 80 хувиас дээш  | Гүйцэтгэл-ээр                   | 85%                             | -   | - Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлтгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор нийслэлийн засаг захиргааны байрууд, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдаас сэтгэл ханамжийн судалгааг авах ажлыг 2020 оны 04 дүгээр сард цахим хэлбэрээр зохион байгууллаа. Судалгааны дүнгээс харахад судалгаанд оролцогчдын 85% буюу дийлэнх хэсэг нь сайн үнэлгээ өгсөн ба төрийн албан хаагчдаас гаргасан санал, хүсэлтийг судлан үзэж, шийдвэрлэн ажиллах үүргийг холбогдох албан хаагчид өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. |
|   |  | Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх | Гүйцэтгэл-ээр   | 327 ажилтан албан хаагч<br>100% | 272 243 500₮                    | 2020 онд тээврийн зардалд 30 239 500 төгрөг, хоолны зардалд 242 004 000 төгрөгийг тус тус зарцуулсан байна.   |   |
| 5 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх    | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг                       | Жилд 1-ээс доошгүй удаа   | 1                               | -                               | - Төлөвлөсөн хуваарийн дагуу 2 дугаар улиралд тус ажлыг зохион байгуулах байсан боловч дэлхий нийтэд коронавируст цар тахал тархсантай холбогдуулан улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж олон нийтийг хамарсан аливаа үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглосон тул хойшлуулсан болно.<br>- Цаг үеийн нөхцөл байдлаар уялдуулан "Амны хаалт-Таны баталгаа" чөлөнг хөдөлгөөнийг өрнүүлэн НЗЗ-ны байруудад үйл ажиллагаа явуулдаг төрийн албан хаагч нарыг уриалан ажилласан.<br>- Мөн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, биеийн дархлааг дэмжих зорилгоор ажилтан, албан хаагчдад витаминжуулалтын аян зохион байгуулсан.<br>-Цар тахалтай хариу арга хэмжээний хүрээнд 280 ажилтан, албан хаагчдыг коронавирусийн PCR шинжилгээнд бүрэн |   |

|   |  |                                 |          |       |   |  |
|---|--|---------------------------------|----------|-------|---|--|
|   |  |                                 |          |       |   | хамруулсан.  |
|   |  | Албан<br>хаагчдын<br>хамрагдалт | 100 хувь | 97.1% | - | - Мөн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх,<br>биеийн дархлааг дэмжих зорилгоор ажилтан, албан хаагчдад<br>витаминожуулалтын аян зохион байгуулсан.<br>-Цар тахалтай хариу арга хэмжээний хүрээнд 272 ажилтан,<br>албан хаагч болон нийт ажилтнуудын 97.1 хувийг<br>коронавирусийн PCR шинжилгээнд хамруулсан. |
| Хэсгийн дундаж: 96.4% 995 105 599₮          |  |                                 |          |       |   |  |
| Үнэлгээний дундаж хувь: 94.8 % 996 575 599₮ |  |                                 |          |       |   |  |



**ТАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ**  
**ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолын 11 дүгээр хавсралт**

Хүснэгт 9

| №   | Шалгуур үзүүлэлт  | Хэрэгжилт   | Хувь |
|---|---|---|------|
| <b>Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал</b> |   |   |      |
| 1.  | Эрхэм зорилго, түүний хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулан, тухай бүр шинэчлэх  | Байгууллагын эрхэм зорилго, зорилт болон тэдгээрийн хүрээнд газрын зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон дотоод үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг үндсэн 4 чиглэлээр тухай бүр нь байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудас <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> -д нээлттэйгээр мэдээлэн ажиллаж байна.   | 100% |
| 2.  | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа байршуулан, тухай бүр шинэчилсэн байдал               | Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм журам, стандарт, дээд газраас ирсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн байдал, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар мэдээ, мэдээллийг тухай бүр нь байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудас <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> -д байршуулан ажилласан. Байгууллагын цаг үеийн шинж чанартай мэдээ, мэдээллийг мэдээллийн самбарт 28 удаа, <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> цахим хуудаст 48 удаа, байгууллагын пэйж хуудаст 113 удаа, НЗДТГазрын <a href="http://www.ulaanbaatar.mn">www.ulaanbaatar.mn</a> цахим хуудаст 2 удаа тус тус байршуулан байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилласан. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал 20%-иар өссөн байна. Тайлант хугацаанд нийт 7 төрлийн журам, 2 стандартыг шинэчлэн боловсруулж, байгууллагын вэб хуудаст байршуулсан байна. | 100% |
| 3.  | Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх  | Мөн ННҮГ-ын үндсэн 7 чиг үүргийн хэрэгжилтэд хэрэглэгчдийн үнэлгээг тогтоох зорилгоор сэтгэл ханамжийн судалгааг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдаас цахимаар буюу дотоод удирдлагын систем /ERP/-ээр авч, ирүүлсэн санал хүсэлтийг үе шаттайгаар шийдвэрлэн ажиллаж байна.   | 100% |
| Хэсгийн дундаж хувь:                      |   |   | 100% |
| <b>Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал</b>  |   |   |      |
| 1.  | Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах | Ажлын байрны 73 сул орон тоонд байгууллагын <a href="http://www.khangardi.mn">www.khangardi.mn</a> цахим хуудас, мэдээллийн самбар, <a href="http://www.unegui.mn">www.unegui.mn</a> вэб хуудсаар нээлттэй зарлан, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдээс ирүүлсэн зуучлалын мэдэгдлээр 115 ажил горилогч материалаа ирүүлж, нөөцөд бүртгэгдсэн ба анкет, хувийн хэргээс сонгон шалгаруулалт хийх замаар ажлаас чөлөөлөгдсөн, жирэмсний амралттай, тэтгэвэрт гарсан, захиргааны чөлөөтэй ажилтан, албан хаагчдын сул орон тоонд 41 ажилтан, албан хаагчийг шинээр ажилд авч хөдөлмөрийн гэрээг байгууллаа.  | 100% |

|                           |   |  |      |
|---------------------------|---|--|------|
| 2.                        | Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх  | ННҮГ-ын даргын 2019 оны А/20 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын ёс зүйн дүрэм”, байгууллагын “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг байгууллагын цахим хуудас <a href="http://www.khangardi.mn/">/www.khangardi.mn/</a> -д байршуулсан.   | 100% |
| 3.                        | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэлж байх                                   | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр байгууллагын цахим хуудас <a href="http://www.khangardi.mn/">www.khangardi.mn</a> -д хөдөлмөрийн харилцаатай холбоотой эрх зүйн акт, ажлын байрны сул орон тоотой холбоотой зар, ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор зохион байгуулсан сургалтууд, шинээр ажилд орсон албан хаагчдын талаар мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсын хүний нөөцийн ил тод байдлын хэсэгт тухай бүр шинэчлэн байршуулж ажилласан. | 100% |
| 4.                        | Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэлж байх | Байгууллагын хэлтэс, албадын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын мэдээ, ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалт болон ажлын ур чадвар дүгнэсэн мэдээ, ННҮГ-аас үзүүлж буй үйлчилгээнд хэрэглэгчдээс өгсөн сэтгэл ханамжийн судалгааны дүн зэрэг мэдээ, мэдээллийг байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудас <a href="http://www.khangardi.mn/">/www.khangardi.mn/</a> хуудаст тухай бүр байршуулан ажилласан.   | 100% |
| Хэсгийн дундаж хувь:      |   |  | 100% |
| Хэрэгжилтийн дундаж хувь: |   |  | 100% |

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ. БУСАД ЦАГ ҮЕИЙН АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

5.1 Нийслэлийн Засаг даргын А/1016 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангаж ажилласан талаар:

Тайлант хугацаанд Нийслэлд түүхий нүүрсний хэрэглээг халж сайжруулсан шахмал түлшийг нэвтрүүлснээр Монгол Улсын Засгийн газрын “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоол, НЗДаргын А/1016 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин Сонгинохайрхан дүүргийн 4, 26, 36 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 10 борлуулалтын цэгийн сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлт, борлуулалтад хяналт тавин ажиллаж, хороодоос ирсэн мэдээг нэгтгэн 7 хоног бүрийн Даваа, Пүрэг гаригуудад Нийслэлийн Засаг даргын тамгын газарт цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлэн ажилласан.

Нийслэлийн Онцгой комиссын шийдвэр, хотын ерөнхий менежерийн тушаалын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-10-ны өдрийн хугацаанд захиргаа, санхүүгийн хэлтсийн албан хаагчид СХДүүргийн 4, 26, 36 дугаар хороодын 10 цэгт 24 цагийн хяналт тавин ажиллаж шахмал түлшний нийлүүлэлт, борлуулалтын мэдээг 15, 22 цагийн давтамжтайгаар нэгтгэн НЗАА-нд цахимаар хүргүүлж ажилласан.



Зураг 58. Сайжруулсан шахмал түлшний нийлүүлэлт, түгээлтэд хяналт тавих үер

Нийслэлийн шуурхай штабт ерөнхий зохицуулагч буюу хариуцлагатай эргүүл жижүүрийн үүргийг газрын дарга Х.Эрдэнэбилэгээр ахлуулсан захиргаа, санхүүгийн хэлтсийн 16 албан хаагч 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр “Тавантолгой түлш”ХХК болон 6 дүүргийн борлуулалтын цэгүүдэд 24 цагаар хяналт тавин гүйцэтгэлээ.



Зураг 59. Нийслэлийн шуурхай штабт ерөнхий зохицуулагч буюу 24 цагийн эргүүл жижүүр хийж ажилласан үер

Сонгинохайрхан дүүргийн 4, 26, 36 хороодын айл өрхүүдэд 2020 оны 01 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд 6494 ширхэг, 09 дүгээр сарын 10,11-ний өдрүүдэд 112 ширхэг угаарын хийн мэдрэгч төхөөрөмжийг ашиглах заавар зөвлөмжийн хамт тарааж, суурилуулан ажиллалаа.



Зураг 60. Угаарын хийн мэдрэгчийг тараах үеэр

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах зарим арга хэмжээний тухай” А/346 дугаар захирамжийн хүрээнд угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмжийг [www.Khangardi.mn](http://www.Khangardi.mn) цахим хуудас, “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар” пэйж хуудас, байгууллагын ажилтан, албан хаагчдын нэгдсэн групп, ERP дотоод удирдлагын систем зэрэг боломжит бүх мэдээллийн эх сурвалжуудад нийт 10 долоо хоногийн турш байршуулан ажилтан, албан хаагчид болон иргэд олон нийтэд сурталчлан ажилласан.



Зураг 61. Зөвлөмжийг байгууллагын ажилтан, албан хаагчдын нэгдсэн группт байршуулсан байдал

5.2. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын талаар:

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллахтай холбогдуулан байгууллагын 260 ажилтан, албан хаагч 02 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдөр хүртэлх хугацаанд хуваарийн дагуу ХУД-ын 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Эргүүл”-ийн албан үүргийг гүйцэтгэн иргэдэд амны хаалт тогтмол зүүх шаардлага тавин, аж ахуй нэгж байгууллагуудад ариутгал халдваргүйтгэл хийгдсэн эсэхэд хяналт тавин ажилласан.



Зураг 62. Эргүүлээр ажиллаж буй байдал

Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын баталсан “Амны хаалтаа зүүцгээе” аяны хүрээнд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан “Амны хаалт-Таны баталгаа” чэлленж хөдөлгөөнийг видео хэлбэрээр өрнүүлэн НЗЗ-ны байруудад үйл ажиллагаа явуулдаг төрийн албан хаагч нарыг уриалан олон нийтийн сүлжээнд байршуулан ажилласан.



*Зураг 63. Тус чэлленж хөдөлгөөний үед зохиогдсон арга хэмжээний үеэр*

Халдварт цар тахал дэгдсэнтэй холбогдуулан 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Өлзийт, Баянзүрхийн шалган нэвтрүүлэх товчоодод тус газрын 3 ажилтан 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажилласан.



*Зураг 64. Шалган нэвтрүүлэх товчоонд ажиллаж буй төрийн албан хаагчдад хоол цайгаар үйлчиллээ*

Нийслэлийн нутаг дэвсгэрт “Ковид-19 халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуулилтын бэлтгэл ажлыг хүрээнд 2020 оны 05 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд 24 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр Буянт-Ухаа спортын ордонд 300 ортой эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн хэсэг, үйлчлүүлэгчдийн хувцас солих өрөө, хоолны өрөөний хаягжилт, дугуй хөтөч тэмдэг тэмдэглэгээг хийж тохижуулж газрын цэвэрлэгээ үйлчилгээг хийж, бэлэн байдлыг ханган холбогдох албаны удирдлагуудад хүлээлгэн өгсөн.



*Зураг 65. Халдварт цар тахлын үед ажиллахад зориулагдсан 300 ортой эмнэлгийн бэлтгэл ажлыг ханган удирдлагуудад хүлээлгэн өгч буй үе*

“Ковид-19 халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуулилт 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдаж, НЗЗ-ны 4-н байранд орох гарах хөдөлгөөнийг бүрэн хязгаарлах арга хэмжээг авч, хөл хорионы дэглэмийг сахиулан ажиллалаа.



Зураг 66. Сургуулилтын үеэр өндөржүүлсэн бэлэн байдлаар ажиллаж буй байдал

НЗЗ-ны 2 дугаар байрны үйлчилгээний ажилтнуудыг санаачилгаар Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын ажилтан, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор витаминжуулалтын ажлыг зохион байгуулсан.



Зураг 67. Витаминжуулалт хийж буй байдал

Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тухай” 178, 181 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1242 дугаар захирамжийг тус тус үндэслэн цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хариу арга хэмжээ авах талаар зохион байгуулалт хийх, түүнд хяналт тавьж ажиллах, ажилтан, албан хаагчдын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх зэргээр А/60, 61, 62, 63 дугаар тушаалыг баталж, тушаалын хэрэгжилтийг хангуулан ажилласан. Үүнд:

НЗЗ-ны байруудад коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр хамгаалах хувцас, ариутгалын бодис, хэрэглэлээр ханган, шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн.



Зураг 68. Шаардлагатай хэрэгслийн нөөцлөлт

Байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийн нэмэгдүүлэн гарын шингэн саван, гар ариутгагч байрлуулсан. Ажлын өрөөний өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлж, байруудын гадна, дотор орчны 41.636м2 талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутам хийж гүйцэтгэж байна.



Зураг 69. Байруудад ариутгал, халдваргүйжүүлэлт хийгдэж буй явцаас

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдыг нэвтрүүлэхдээ халдвар, хамгааллын дэглэмийг чанд сахин байгууллагаас ирүүлсэн нэрсийг ажлын үнэмлэхтэй тулган тэмдэглэл хөтлөн, QR кодыг уншуулан, гарыг ариутган халдваргүйжүүлж байна.



Зураг 70. Бүртгэл хөтлөн, халууныг хэмжин, смарт хаалгаар нэвтрүүлж буй явцаас

Мөн төрийн байгууллагад цар тахлын сэжигтэй тохиолдол илэрсэн үед ашиглах, тусгаарлах өрөөг 12 байршилд бэлтгэж бэлэн байдлыг хангаж ажиллалаа.



Зураг 71. Тусгаарлах өрөөг бэлэн болгосон байдал

### 5.3 Бусад ажлын хүрээнд:

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт байрлах Сэлбэ дэд төвийн байрыг 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр хүлээн авч, ашиглалтыг хариуцан ажиллаж байна.



*Зураг 72. Сэлбэ дэд төвийн байр*

Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.1-д “Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох “Хотын соёл” олон нийтийн аян өрнүүлнэ” гэж заасны дагуу нийтийн соёлыг дээшлүүлэх үүднээс “Хотын соёл” аяныг зохион байгуулагдсан. Тус аяны удирдамжийг байгууллагын онцлогтоо тохируулан үйл ажиллагаандаа тусган ажилтан, албан хаагчдын нүүр хуудсын зургийг “Хот соёлтой болгоё” фрэйм байршуулан сурталчлах ажлыг 1 сарын хугацаанд зохион байгуулж, “Соёлтой цэвэр орчин бүрдүүлцгээе” аян зохион байгуулан байруудын гадна талбайн орчны 50метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай хогийн цэг, тамхи татах цэгүүдэд “Олон нийтийн газар нус, цэр, шүлсээ хаяхгүй, ил задгай хог хаягдлаар орчноо бохирдуулахгүй байх” гэсэн “САНАМЖ”-ийг байршуулж, байгууллагын боломжит бүх эх сурвалжаар дамжуулан иргэд олон нийтийг хотын соёлд уриалан сурталчлан ажилласан. Тайланг сар бүр холбогдох газарт хүргүүлсэн.



*Зураг 73. Тус аяны хүрээнд хэрэгжүүлсэн ажлын явцаас*

Нийслэлийн ойн 381 жилийн ойн баярыг тохиолдуулан ажилтан, албан хаагчид болон иргэдэд нийслэлийн өдрийн баярын мэнд дэвшүүлж, угтан авах үйлчилгээг баяр ёслолын байдалтайгаар зохион байгуулж ажиллалаа.



*Зураг 74. Угтан авах үйлчилгээний явц*



## ДОЛОО. ДҮГНЭЛТ

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны “Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд нутгийн захиргааны байгууллага болон төрийн албан хаагчдад үзүүлэх төрийн үйлчилгээний чанар стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээг үзүүлж, үр дүнг тооцож ажилласан.

Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, захирамж, албан даалгаврын хүрээнд хамааралтай заалт, дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг ханган, олон шинэлэг ажлуудыг хэрэгжүүлж, байгууллагын ил тод байдал, төсөв санхүүгийн сахилга батыг ханган ажиллалаа.

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь ажилтан, албан хаагчдынхаа нийгмийн асуудал, сурч боловсрох, тэдний ажиллах нөхцөл боломжийг сайжруулахад анхааран, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлэн ажиллаж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ, үйл ажиллагаагаа бүрэн хангалттай хэрэгжүүлж ажилласан.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолоор улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан улсын онцгой комиссын 22 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/590, А/752 дугаар захирамжаар 2020 оны 06 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл олон нийтийг хамарсан аливаа үйл ажиллагаа, сургалт семинар зохион байгуулахыг хориглосон тул зорилтот жилийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн зарим үйл ажиллагаа, арга хэмжээ тодорхойгүй хугацаагаар хойшилсон болно.

Манай байгууллага нь Тайлант хугацаанд дүрмээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, цаг үеийн шинж чанартай дээд газраас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачилгатай хамрагдан, өгөгдсөн үүрэг чиглэлийг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэн ажиллаа.

ТАНИЛЦСАН:

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА  Ч.ШИНЭЧИМЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АЖИЛ, СУРГАЛТ  
ХАРИУЦСАН АЖИЛТАН  Ц.ҮРЭЛМАА